

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН**



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

| | |
|--|------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 1-7 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 8-53 |

| | |
|--|-------|
| 1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/ | 8-32 |
| 2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 32-51 |
| 3.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 52 |

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 18-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 49 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар
2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх Н.Лувсанжав, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт.
Нэгдүгээр зүйл.

Н.Энхболд: Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар аргаар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 15
Бүгд: 15
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д заасны дагуу ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүний далан зургааг тойргоос сонгуулийн олонхыг төлөөлөх /мажоритар/, тавийг улсын хэмжээний нэг тойргоос хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцооны зарчмаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“1.Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүний далан зургааг тойргоос сонгуулийн олонхыг төлөөлөх /мажоритар/, тавийг улсын хэмжээний нэг тойргоос хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцооны зарчмаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг хоёр дахь удаа явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх санал хураалт найруулгын засвартайгаар дэмжигдэв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Х.Нямбаатар нараас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Н.Энхболд: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх Н.Лувсанжав, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар Монгол Улсын Засгийн газраас болон ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Н.Энхболд нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар нэмэлт тодруулга хийх талаар мэдэгдэж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх Н.Лувсанжав, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн 2 цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./16:27/

Хуралдаан 20 цаг 42 минутаас үргэлжлүүлэн хуралдав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./20:43/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Т.Доржханд, Х.Нямбаатар, Д.Сарангэрэл, Д.Тогтохсүрэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 1 дүгээр зүйл нэмэх:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“1 дүгээр зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.4-т заасны дагуу нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн Нэгдүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын нийт гишүүний тоо Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу олныг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх санал найруулгын засвартайгаар дэмжигдлээ.

4.Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Н.Энхболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Н.Энхболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Н.Энхболд үг хэлэв.

Уг асуудлыг 21 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 21 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон
“Их эзэн Чингис хаан” танхим
13 цаг 49 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 05 ДУГААР
САРЫН 18-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/
ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний 57.9 хувь буюу 11 нь хүрэлцэн ирсэн учраас 2023 оны 5 сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл мөн Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар Байнгын хороо хэлэлцэнэ.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хууль санаачлагчдыг төлөөлж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Баасандорж, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чойжилсүрэнгийн Ариунхур Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах зөвлөх, Нинжбатын Ууганбаатар МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор, Дагва-Очирын Бумдарь МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор ийм ажлын хэсэг оролцож байна.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 13.1 хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг Төрийн байгуулалтын байнгын хороо нэгтгэн зохион байгуулна.

Бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ өөрсдийнхөө Байнгын хороогоор хэлэлцээд Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

санал, дүгнэлтээ гаргана гэж заасны дагуу Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх бусад Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсох ийм дэгтэй.

Ингээд байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсьё.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат танилцуулна.

Ж.Эрдэнэбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг нь сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын

6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно оо.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргаагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 72.7 хувийн саналаар дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтсон.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж ирэхийг хүсье.

Н.Энхболд: Эрдэнэбат гишүүнд баярлалаа.

Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Ганболд гишүүн танилцуулна. Байнгын хорооны санал дүгнэлт.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журам журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлдүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоолд Монгол Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбогдуулан асуулт асуугаагүй бөгөөд зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос дээш буюу 64.3 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Н.Энхболд: Ганболд гишүүнд баярлалаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал дүгнэлтийг Адьясүрэн гишүүн танилцуулна. Адьясүрэн гишүүний микрофоныг өгье.

А.Адьясүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт Монгол Улсын үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн

хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.11 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Түүнчлэн Монгол Улсын үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл тус бүрээр хэлэлцэж төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Адьясүрэн гишүүнд баярлалаа.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны санал санал, дүгнэлтийг тус хорооны гишүүний хувьд би танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-нд тэр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хуралд 2023 оны 5 сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 сарын 6-наас 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороо 23 оны 5 сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцлээ.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу тус төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ асуулт асууж, хариулт авсан болно оо.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрөөтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 85.7 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцууллаа.

Одоо Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн байна? Доржханд танилцуулна.

Идэрбат гишүүн танилцуулах юм байна.

Ц.Идэрбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд Монголд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Инновац, цахим бодлогын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэл хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрөөтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтсон.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: *Идэрбат гишүүнд баярлалаа.*

Одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл танилцуулна.

Д.Сарангэрэл: *Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн

хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг ард нийтийн санал асуулга явуулах замаар иргэдийн саналыг авч шийдвэр гаргахдаа харгалзан үзэх шаардлагатай бөгөөд энэ талаар хуулийн ямар зохицуулалт байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг, Идэрбат, Батлут нараас Улсын Их Хурлын гишүүдийн тоог тогтоосон үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг мажоритар, пропорциональ аргаар сонгогдох гишүүдийн тооны харьцааг хатуу тогтоосон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлснээр гишүүний ажлын албаны бүрэлдэхүүний тоо нэмэгдэх эсэх, уг төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн гурав дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 8 жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглоно гэсэнтэй зөрчилдөж байгаа эсэхийг тодруулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Идэрбат Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болговол судлаачдын тооцсон үр дүнтэй нийцэх

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 84.6 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Сарангэрэл гишүүнд баярлалаа.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн танилцуулна.

Тогтохсүрэн гишүүнийг урьж байна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа.

Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр, гурав дугаар хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд Хоригтой ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 23 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлоо сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Төсвийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль нь 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Монгол Улсын үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг иргэд шууд сонгох эрхтэй гэж заасан нь хэлэлцээж байгаа төсөлд туссан пропорциональ аргатай хэрхэн нийцээж байгаа талаар асуулт, асууж хариулт авсан болно.

Түүнчлэн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы тухай чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь буюу 84.6 хувийн саналаар дэмжиж Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлээд тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүнд баярлалаа.

Одоо Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат танилцуулна.

Ж.Эрдэнэбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг нь сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйл зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг ард нийтийн санал асуулга явуулах замаар иргэдийн саналыг авч шийдвэр гаргахдаа анхаарахад хуулийн ямар зохицуулалт байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэхэд уг төслийг өргөн мэдүүлсэн Засгийн газрын ажлын хэсэг тайлбар өгөх бус Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсэг танилцуулга хийх боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 83.3 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Энхболд: Эрдэнэбат гишүүнд баярлалаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Нямбаатар гишүүн танилцуулна. Нямбаатар гишүүн ээ, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Х.Нямбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, Улсын Их Хурлын гишүүдийн тойрогт ажиллах тухай Улсын Их Хурлын даргын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг заасныг баримтлан хэлэлцэн болно.

Түүнчлэн Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд Ерөнхийлөгч Улсын Их Хурал Засгийн газар өөрийн бүрэн эрхийн хүрээнд хязгаарлах асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл санаачилж болохгүй гэсэн заасан бөгөөд Засгийн газраас санаачилсан төслийг Улсын Их Хуралтай холбоотой заалтыг гишүүд санал гаргаж өөрчлөх эрх байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Улсын Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 80 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Нямбаатар гишүүнд баярлалаа. Одоо Эдийн засгийн байнгын хорооны дүгнэлтийг Оюунчимэг гишүүн танилцуулна. Оюунчимэг гишүүнийг урьж байна.

М.Оюунчимэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, “Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай” Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 5 дугаар сарын 6-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбогдуулан асуулт асуугаагүй бөгөөд зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй буюу 80 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүнд баярлалаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт түүнийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулиудын төслийн талаар Байнгын хороодоос ирсэн санал, дүгнэлтүүдийг танилцуулж дууслаа.

Одоо дэгийн дагуу ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас 2023 оны 5 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 5 сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд дэмжсэн.

Монгол Улсын Их Хурлын 23 оны 5 сарын 5-ны өдрийн 37 дугаар тогтоолоор

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Энхболдоор ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа, Батсуурь, Доржханд, Нямбаатар, Сарангэрэл, Тогтохсүрэн, Цогтгэрэл, Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ажлын хэсэг энэ хугацаанд 3 удаа хуралдлаа.

Улсын Их Хурлын даргын захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийн иргэдэд танилцуулах санал бодлыг нь сонсох ажлыг Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3 дахь хэсэгт нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын бүх Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлснийг та бүхэнд танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.9 дэх хэсэгт хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа эрхлэх асуудал нь хамаарах Байнгын хороонд танилцуулахаар заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн тойрогтоо ажилласан тайлан, иргэдээс танхимаар болон бичгээр ирүүлсэн саналуудыг харгалзан ажлын хэсэг дараах саналыг гаргаж,

Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Энэ саналуудаа та бүхэнд томъёолоод хүргэчихсэн болохоор би энийг уншихаа болиод товчилчихъё.

Санал асуулга иргэдийн санал бодлыг судлах ажлын хүрээнд урьдчилсан дүнгээр иргэд сонгуулийн холимог тогтолцоог зарчмын хувьд дамжиж байна. Харин гишүүдийн тоог төсөлд зааснаас бууруулах нь зүйтэй гэсэн зонхилох санал гарсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг хүртэл энэ санал авах ажиллагаа үргэлжилнэ. Эдгээр байдлыг харгалзан үзээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал 1 танхимтай, 126 гишүүнтэй байхаар гишүүдийн 76-г мажоритар, 50-ийг пропорционалиар сонгох агуулах биш агуулга бүхий саналыг ажлын хэсгээс Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гэсэн нэг дэх заалт нэмэх, ийм агуулгатай заалт нэмэх, төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд 20 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрх хэвээрээ байна гэж, хадгална гэж, төслийн 2 дугаар зүйлийг салгаж 3, 4 дүгээр зүйл болгон өөрчилж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн баталж, мөрдөх хүртэл

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хугацаанд тухайн хуулийг зохицуулж ирсэн хуулиудыг дагаж мөрдөнө гэж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлын 2024 оны 6 сарын 1-ний өдөр хийж дуусгана гэж тус тус өөрчлөн найруулах.

Мөн төсөлд энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй гэсэн агуулга бүхий 5 дугаар зүйл нэмэх зэрэг нийт 6 зарчмын зөрүүтэй саналыг ажлын хэсгээс Төрийн байгуулалтын хороонд оруулж байгаа. Төслүүдийг та бүхэнд тараасан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Дэгийн дагуу хууль санаачлагчаас асуулт асууж болно. Асуулт асуухдаа 1 гишүүн 8 минутад багтааж асуугаад, нэмэлт асуулт тавих шаардлагатай бол 2 минутад багтаана. Хариултыг 8 минутад багтааж өгнө. Нэмэлт тайлбар, хариулт хэрэгтэй бол 1 минутад багтаана гэсэн дэгийн заалттай. Ажлын хэсгээс асуух юм. Нөгөө хуулиудынхаа томъёолол дээр асуугаад явчихъя. Одоо хууль санаачлагчаас тийм. Ажлын хэсэг тусдаа, хуулиудаа хэлэлцэх үед нь асуугаад явчихна. Тийм.

Хууль санаачлагчаас асуулт асуух гишүүн байвал нэрээ өгье. Хууль санаачлагчаас асуух гишүүн байхгүй байна. Одоо гишүүд тарааж өгсөн

хуулиудынхаа төслийн томъёололтой танилцаад ингээд асуулт асууж болно. Ажлын хэсгээс. Одоо ингээд ажлын хэсгээс боловсруулж та бүхэнд хүргэсэн саналуудаараа санал хураалт явуулна, танилцуулна. Танилцуулсны дараа тэрэнтэй холбогдуулаад гишүүд асуугаад явчихаарай.

Санал хураалтыг ийм байдлаар явуулна. Дэгээ танилцуулчихъя. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж болно. Саналаа урьдчилж бичгээр томъёолж хуралдаан даргалагчид өгсний үндсэн дээр үндэслэлийг нь тайлбарлаж 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж, санал хураалгах эрхтэй. Гишүүнд хуралдаанд өөрөө оролцоогүй ч гэсэн санал хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой санал ирүүлсэн бол хэлэлцэж санал хураалт явуулж болно.

49.5 дахь хэсэгт саналын 1 томъёоллоор 3 хүртэл удаа санал хураана. 2 удаа Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны дэмжсэн санал гэж үзэж нэгдсэн хуралдаанд оруулна.

Төрийн байгуулалтын байнгын хороо холбогдох Байнгын хороо, нам эвслийн бүлгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын үндэслэлийг санал тус бүрээр 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлан санал хураалгана.

Мөн 3-ны 2-оос доошгүй дэмжлэг авсан саналуудыг нэгдсэн хуралдаанд оруулна. Гишүүдийн 3-ны 2-оос доошгүй дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд туслах шаардлагагүй санал гэж үзэж, үндэслэл шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураахдаа төслийн зүйл, хэсэг тус бүрээр хамтатган санал хураана гэж заасан.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах тухай санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүйг нь дэмжсэн бол хоёр дахь хэлэлцүүлэгт бэлдсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал, дүгнэлтээ гаргана гэсэн ийм дэгийн зохицуулалттай.

Одоогийн байдлаар бичгээр зарчмын зөрүүтэй санал гишүүдээс болон Байнгын хороодоос, бүлгүүдээс энэ хэнийх юм, ажлын хэсгийн гишүүнээс санал ирүүлэх шаардлага байгаа юм болов уу даа Нямбаатар гишүүнээ. 2 санал ирсэн юм байна. Пүрэвдорж гишүүнээс 1 санал ирсэн байна. Тухай тухай хэсэг дээр нь явчихъя. Тэгээд дараа нь Нямбаатар гишүүнээс ирсэн саналыг хураалгана.

Айн? Биш ээ ингэж явна. Эхлээд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн төслөөр санал хураана. Тэр санал унавал, унавал ажлын хэсгийн саналаар санал хураана. Тэр санал дэмжигдвэл тэрнээс хойш түүнтэй зөрчилдсөн саналуудаар санал хураах шаардлагагүй гэж үзнэ. Ийм дарааллаар явна.

Тийм хэлсэн, сая хэлсэн. Одоо ингээд саналын томъёоллоо танилцуулна. Тэгээд тэрэнтэй холбогдуулж гишүүд асууж, үг хэлж болно.

Санал хураалгах дэг дарааллыг та бүхэнд танилцуулсан. Одоо хууль санаачлагч Монгол Улсын Засгийн газрын зүгээс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн тухай хуулийн томъёоллыг уншиж танилцуулна. Тэгээд санал хураана. Санал болгоныг 3 хүртэл удаа хураана. 2 удаа дэмжигдсэнгүй, дэмжигдээгүй бол түүгээр нь шийдээд явах ийм дэгтэй.

Би томъёолол танилцуулъя. Засгийн газраас оруулж ирсэн томъёолол.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт.

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Улсын Их Хурал нэг танхимтай байна. Улсын Их Хурлын гишүүдийн далан зургааг мажоритар аргаар, далан зургааг пропорциональ аргаар сонгоно гэсэн томъёололтой хуулийн төсөл байна.

Гишүүд анхааралтай хандаарай. Энийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. 15 гишүүн санал хураахад оролцож, 100 хувийн саналаар төслийн санал дэмжигдсэнгүй.

Айн? Одоо өөрөө л мэд дээ, тийм.

Одоо 2 дахь санал. Ажлын хэсгийн санал хураалт явах гэж байна Доржханд гишүүнээ саяын таны асуулт. Тийм. Одоо намайг уншихаар наадах чинь түрүүчийнх нь санал хураагаад дуусчихлаа шүү дээ Пүрэвдорж гишүүнээ тийм ээ? Одоо саналаа уншина тэгээд та асуугаарай.

Ажлын хэсгээс оруулж байгаа санал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын гишүүний далан зургааг тойргоос сонгуулийн олонхыг төлөөлөх хашилтад мажоритар таслал тавийг улсын хэмжээний нэг тойргоос энэ хувь тэнцүүлэх хашилтад пропорциональ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тогтолцооны зарчмаар сонгоно. Ажлын ажлын хэсгийн санал.

Түрүүн би ажлын хэсэгт орсон гишүүн 9 гишүүний нэрийг хэлсэн. Асуух хүн байна уу? Нэрээ Пүрэвсүрэн гишүүнээр, Батсуурь гишүүнээр, ажлын хэсгийн гишүүд бие биеэсээ асуугаад байх хэрэг байна уу гишүүд ээ? Биш биш Сүхбаатар гишүүн, Занданшатар гишүүн, Пүрэвдорж гишүүн бас байгаа. Яах юм Тогтохсүрэн гишүүн? Тэгвэл дараа нь больё. Сүхбаатар гишүүн асууя. Хэлчих, хэлчих. Асуулт, санал нэг байгаа Сүхээ гишүүнээ саналаа хэлчих.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Үндсэн томъёоллыг дэмжиж байгаа. Ажлын хэсгээс оруулсан, бас манай ажлын хэсэг, дэд хэсгийнхэн ажилласан. Энэ чинь бас олон удаагийн Үндсэн хууль дээр ажиллаж байсан бас Үндсэн хуулийн редакт томъёолол бол өөрийн гэсэн бас онцлогтой ийм байдаг. Энэ чиглэлээр нь манайхан хэл найруулга гээд дээр ажилласан байна.

Би бол зүгээр тэр 2 үгийг хасчихмаар байгаа юм. Тэр далан зургааг тойргоос гэдэг энэ тойргийг, улсын хэмжээний нэг тойргоос гэдэг энэ 2 үгийг хасчихмаар байгаа юм. Үндсэн хууль дээр хэт жижгэрч улсын хэмжээний 1 тойрог гэж оруулж болохгүй байх гэж бодож байна. Явцын дунд энэ чинь 20, 30 цаашилбал 100 жил үйлчилнэ. Явцын дунд тэгээд 1 тойрог байх уу, олон тойрог байх уу гэдэг юм бол гарч ирэхийг үгүйсгэхгүй. Бүсчлээд эд нар юм хум гараад байдаг шүү дээ. Энэ пропорциональ чинь их олон янз байдаг юм байна лээ. Нэг тойргоос байдаг, бүсчилсэн тойргоос байдаг гээд олон юм байдаг юм байна лээ.

Тийм учраас бол энэ улсын хэмжээний нэг тойрог, тойрог гэдэг 2 үгийг хасаад л ерөнхий энэ том нөгөө тогтолцоогоо дурдчихсан, мажоритар, пропорциональ 2 эд эд байна гээд харьцаагаа дурдчихсан, гишүүнийхээ

тоог дурдчихсан ийм л зарчим байвал яасан юм.

Ер нь Үндсэн хууль дээр хэт нарийвчилж болохгүй байх гээд агуулгаар нь би тийм 2 үгийг редакцаар хэдүүлээ энэний дараах хасаад тэгээд явчихвал яасан юм бэ л гэж бодож байгаа юм. Бусдыг нь бол дэмжиж байна.

Н.Энхболд: Санал. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Би зүгээр 2 хувилбараар хэлье, саналаа хэлье. Нэг нь одоогийн байгаа манай ажлын хэсгийн оруулж ирж байгаа дээр зүгээр үг, үсгийн найруулгын чанартайгаар хэлье. Их Хурлын гишүүний 76 гэдэг хууль зүйн техникийн хувьд бол буруу. Улсын Их Хурлын нийт гишүүний 76 гэж хэлж болно. Эсвэл Улсын Их Хурлын 76 гишүүнийг гэж хэлэхэд тоог сонгоно гэж хэлж болохгүй шүү дээ. Их Хурлын гишүүний 76, амаараа ярьж байгаа юм шиг тийм ээ? Хууль зүйн техник, соёл, Монгол хэл бичгийн дүрмээр 76-г сонгоно гэж бодож болохгүй шүү дээ энэ чинь амны яриагаар. 76 тийм, 76 гишүүн шүү дээ энэ чинь тодотголтой. Хэрвээ тэгж хийвэл.

Хоёрдугаарт, олонхыг төлөөлөх тогтолцооны зарчмаар пропорциональ тогтолцооны зарчмаар сонгоно гэдэг нэр томъёо чинь буруу. Тогтолцооны зарчмаар сонгож байгаа асуудал биш. Нэг бол ингэж хэлэх гэж байгаа бол тогтолцоогоор сонгоно, эсвэл сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах арга зарчмаар сонгоно гэж томъёолох ёстой байхгүй юу.

Түүнээс энэ чинь зарчмаараа ярих юм бол зарчим чинь олон янзын зарчим л байгаа шүү дээ. Тэгээд тэр аль ч олон янзын зарчмыг нь хэлээд байгаа юм. Яг хувааж байгаа юм бол мажоритар тогтолцоогоор сонгодог, эсвэл пропорциональ тогтолцоогоор л сонгодог байхгүй юу. Тогтолцоогоор гэж том

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үгээр бичнэ гэвэл тогтолцоогоор сонгоно. Эсвэл яг хуулийнх нь хэллэгээр II оны миний, бид нарын, миний оролцож байсан тэр Сонгуулийн хууль дээр байгаа шүү дээ. Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах арга, зарчмаар сонгоно. Энэ чинь арга, зарчим орж байгаа байхгүй юу. Гол тэр систем гэдгийнхээ чинь цаана.

Тэгэхээр юу хэлэх гэж байгаа гэхээр энэ яг одоогийн энэ найруулга чинь хууль зүйн хувьд илэрхий алдаатай, бас их бүдүүлэг тийм. Аягүй бол манай энэ хуульчид чинь энийг харах юм бол өө энэ хэд энэ Үндсэн хуулиа томъёолчихож чадахгүй гээд хэлэхээр бараг энгийн ийм найруулга муутай харагдаж байна. Нэг.

Хоёр дахь миний үндсэн санал уг нь яг бас сонгуулийн эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр 20-оод жил явчихсан хүний хувьд хэлэхэд уг нь юу нь зөв юм бэ гэхээр байна шүү дээ. Түрүүний тэр Тогтохсүрэн даргын хэлээд байгаа тэр улсын хэмжээний гэдэг ийм юм байж болохгүй. Пропорциональ систем чинь бүсчилсэн, Финлянд эд нар чинь бүсчилсэн байгаа шүү дээ. 15, 6 байна уу, 19 бүстэй. Энэ бүсчлэхийг чинь манай улсын бүсчилсэн хөгжлийн чиг хандлага гэж юм байгаа шүү дээ. Энийг чинь шууд хаачихна шүү дээ. Бид нар чинь ямар эгнэгт ингээд пропорционалийг улсын хэмжээний 1 тойрог гэж ойлгож болохгүй шүү дээ. Монгол 5 юм уу, 9 бүсэд хуваагдаж сонгуулиа хийх цаг ирнэ шүү дээ.

Тэгэхээр ингэж улсын хэмжээний тойрог гэж ийм ядмаг ингэж хийж болохгүй. Энэ дэлхийд ийм заалттай улс Үндсэн хууль дээрээ байхгүй. Миний мэдэхийн. Single, нэг тойрог гэж ингэж заана гэдэг бол.

Уг нь томъёолол нь юу юм бэ гэхээр ийм л байхгүй юу. Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын нийт гишүүнийг 3-ны 1-ээс доошгүйг хувь тэнцүүлэн хуваарилах арга зарчмаар сонгоно гэхихээр 3-ны 1-ээс

доошгүй нь хувь тэнцүүлнэ гэхээр үлдсэн эсэх нь мажоритар байж болно гэдэг л санаа байхгүй юу. Уг нь хууль зүйн техник нь ийм л байх ёстой юм. Яг ингээд 76, 50 гэж хуваадаг чинь бас тийм сонин болчихоод байгаа. Яах вэ улс орнууд 50, 50-аараа хуваахдаа бол жишээлбэл Их Хурлын гишүүний хагасыг нь пропорциональ тогтолцоогоор сонгоно, хагасыг нь мажоритараар сонгоно гэж уг томъёолоод хийж болдог.

Яг ингэж тоогоор ингэж явж байгаа нөхцөлд уг нь хувьчилж л хийдэг л арга шүү дээ. Үндсэн хууль хууль зүйн техникийн хувьд хамгийн өндөр соёлыг харуулсан хэмжээний томъёололтой байх ёстой байхгүй юу. Үндсэн хуулийн эрх зүй шүү дээ энэ чинь. Энэ чинь хэдэн хүн сууж байгаад томъёолчихдог асуудал биш.

Тэгэхээр энэ асуудлаараа би тэр улс төрийн тохиролцоо гэдгээ бодоод их тоо руугаа дайраад баймааргүй л байгаа юм. Уг нь 76 гэдэг чинь тэгээд л 78, 48 байж болохоор шүү дээ. 3-ны 1 гээд л хэлчихэд чинь ер нь 42-оос доошгүй гишүүн байна гээд ингээд явчихад Сонгуулийн хууль дээр чинь удахгүй бид хэлэлцэнэ шүү дээ уг нь. Тэгэхээр ингээд хийчихээр яараад нэгэнт тохиролцсон тохиролцоо эвдэхгүй эд нар гээд ингэж байгаад буруу томъёололтой хийчихвэл одоо энэ юу болох вэ гэхээр дараачийн удаа 24 оны сонгуулийн дараа Үндсэн хуулиа өөрчилье энэ томъёолол хачин юм хийчихсэн байна гээд.

Мажоритар, пропорциональ гэдэг нэр томъёог хэрэглэснээр прокурор гэдэг дээр 2 гадаад нэр томъёо оруулна гэдэг бас их маргаан дэгдээнэ. Тэртээ тэргүй л нөгөөдөх нь хувь тэнцүүлэн хуваарилах арга. Нөгөөдөх нь олонхыг төлөөлөх тэр арга зарчмыг л хэлж байгаа юм чинь. Будилж байна гээд заавал мажоритар, пропорциональ гээд өөртөө зориулж хийгээд яах юм бэ.

Түрүүчийн удаа тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 6.1 дээр чинь

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төрийн нийтийн өмч гээд балай юм хийчихсэн шүү дээ. Би тэр үед хэлж л байсан. Нийтийн төрийн өмч гэж байхаас гээд. Тэгэхээр төрийн нийтийн өмч гээд бас онигооны юм хийчихсэн. Одоо энэ шиг ингээд мажоритар, пропорциональ гээд өөрсдөө будилахгүй гээд ийм юм хийчихвэл энэ чинь бас л одоо энэ чинь Үндсэн хуулийн эрх зүйгээр чинь зуу зуун хүүхдүүд хичээл ном заалгаж байгаа шүү дээ.

Тэгэхээр ядаж тэд нарынхаа түвшинээс шүүмжлэгдчихгүй тийм хэмжээний томъёолол хийхгүй бол энэ яг энүүгээрээ бол хангалтгүй байна л гэж би хэлэх гэж байгаа юм. Энийг анхаарна биз гэж.

Н.Энхболд: Санал гэж ойлгох уу? Асуултгүй. Ингэсэн юм, Сүхээ гишүүн ээ. Яг энэ асуудлуудаар нэгдүгээрт зарчмаар гэх үү, тогтолцоогоор гэх үү, аргаар гэх үү, хэлбэрээр гэх үү гэж баахан ярьж байгаад зөвхөн ажлын хэсгийн гишүүд ч биш бас урьд өмнө энэ Үндсэн хуулийг боловсруулахад оролцож байсан, батлалцахад оролцож байсан хуульчид, хүмүүстэй ярьж ярьж байгаад ер нь энэ тогтолцооныхоо зарчмыг үндэс болгоно гэдэг энэ зөв юм байна гэж ингэж томъёолсон юм, нэгдүгээрт.

Тэр тойрогтой холбоотой асуудлыг бас ярьсан. Тэгээд энэ дээр 2 зүйлийг бодолцсон юм.

Нэгдүгээрт, төслөөрөө яг ийм байдлаар орж ирсэн. Мажоритар гэдэг нь тойргоор гээд утгаар.

Хоёрдугаарт, сая хэлэлцүүлгийн явцад бүлгүүд дээр намуудын хэмжээнд ярихдаа энэ тоонуудаа яг тоогоор нь оруулъя, тохирсноороо явъя гээд ажлын хэсэг дээр наана цаана болгохоор бас итгэлцэл алга болчих гээд байна, дэмжлэг байхгүй болно янз бүрийн шалтгаанууд яригдсан.

Гуравдугаарт, 76 тойргоо бол ер нь зарчмын хувьд бүгдээрээ авч үлдэнэ гэж тохирсон учраас бүүр тоогоор нь оруулахгүй бол бас болохгүй. Ингэж оруулж байж анхнаасаа ярьсан, ойлголцол, зөвшилцөл тогтолцоогоороо явна гээд ажлын хэсэг дээр яриад ийм томъёоллуудаар оруулж ирж байгаа юм.

Ер нь бол энэ ажилд эхнээс нь оролцоод явж байгаа, ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд хэлэхэд хэн нэг нь ямар нэгэн байдлаар ийм тоо юм уу, үг, үсэг оруулчихаад дараа нь энэнээсээ бултах, булзах тухай асуудал байхгүй байх гэж бодож байна. Тэгж ойлголцсон.

Тэгэхээр яах вэ, зарчмуудаа бүгдээрээ дэмжиж байна тийм ээ? 1 танхимтай байх дээр асуудал алга, 126 дээр асуудал алга гэж бодож байна. Харин чухам тэр тойргоос гэдгээ заавал тэгж бичих үү, эс үгүй бол дараа нь хэзээ нэгэн цагт шаардлага гарсан үед заавал жижиг тойргоос гэхгүйгээр явуулах уу гэх мэтчилэн ийм зүйл гарч магадгүй гэж үзвэл энийг тойруулаад ярьж болох юм. Одоо ярих уу, ярьчихаад гурав дахь хэлэлцүүлэг дээрээ чиглэл авч байгаад тодруулах уу? Тийм боломж бол хэлэлцэх дгээр байгаа. Хоёр ч заалт байж байгаа. Байнгын хороон дээрээс, Улсын Их Хурал дээрээс дарга чиг өгөөд явахад эдгээрийг дараагийн ээлжид засах, янзлах асуудал байгаа.

Мажоритар, пропорциональ гэсэн үгийг бас бид анх оруулахдаа ер нь ажлын хэсэгт оруулахдаа Засгийн газраас бол мажоритар, пропорциональ гэж үгээрээ орж ирсэн. Бид ярьж байгаад 1 удаа өөрчилсөн. Энийг ерөөсөө олонхыг төлөөлөх хувь тэнцүүлэх гэдгээрээ явъя гэж. Тэгээд дахиад өнөөдөр ажлын хэсэг дээр хуралдахад нэр бүхий гишүүд маань үгүй ээ энэ үгээ заавал оруулъя, оруулж байж энэ их ойлгомжтой болно гээд санал хураагаад, олонх нь дэмжээд ингэж оруулж ирсэн юм. Ийм л байна. Тэгэхээр яах вэ хэдүүлээ? Зарчмын хувьд бол бүгдээрээ дэмжиж байгаа. Цаана байгаа

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

санааг. Томьёо, томьёолол дээрээ л, томьёолол дээрээ л анхаарах асуудал.

Сүхээ гишүүн.

Ж.Сүхбаатар: Яах вэ би зүгээр энэ Энхболд даргыг чинь ойлгож л байна даа. Бид хоёр бол олон жил бас энэ дээр ажиллачихсан улсууд. Сүүлийн үед би залхаад иймэрхүү юман дээр юм ярих дургүй л байгаад байгаа юм. Гэхдээ ингээд хараад байхаар бас хариуцлагагүй хандаж болохгүй л юм байна лээ. Одоо тойргоос гээд биччихэж байгаа юм. Сонгуулийн тойрог гэж хэлдэг юм шүү дээ. Тойргоос гээд ингээд л яг амаараа л биччихсэн байгаа. Үгүй ээ энэ чинь юу гэсэн үг юм бэ энэ чинь тойргоос байхдаа яах вэ дээ. Сонгуулийн тойрог гэж байна шүү дээ энэ чинь.

Тэгвэл Их Хурлын гишүүний 76 гэдгийг чинь Улсын Их Хурлын 76 гишүүнийг Улсын Их Хурлын сонгуулийн тойрог гэх юм уу, сонгуулийн тойрог гэх юм уу гээд л энэ чинь жишээлбэл асуудал. Тэгээд үг, үсэг чинь хөөцөлддөг байхгүй юу. Үндсэн хууль дээр үг, үсэг хөөцөлдөнө шүү дээ хамгийн гол нь. Нэг үгний цаана, Чимэд багш хэлж байсан юм хууль зүйн нэр томьёоны мэргэжилтэн байж байж сая хуульч болно гэж байгаа. Тэгээд л тойргоо сонгоно гээд л ингээд л биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд би тэрийг нь яагаад хэлж байна вэ гэхээр бид нарын амны ярианд шингэчихсэн байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр энэ ингээд болж өгөхгүй байгаад байгаа юм нь энэ байна. 1 тойрог гээд л, single тойрог гэдгийг зүгээр 1 тойрог гээд л биччихсэн. Тойрог гээд л тэгэхэд ингээд л сонгуулийн тойрог юм уу, биш. Тэгэхээр яг энэ асуудал дээр энэ зүгээр ингээд харахад зарчмын хувьд бол тэгвэл өнөөдрийн хувьд ингэвэл ер нь зарчмын хувьд 126, 1 танхим байна тэгээд ер нь 76 байна уу тэр гишүүд сонгуулийн олонхыг төлөөлөх аргаар, 50 нь сонгоно гэдэг бол нэг ийм зарчмаар ингээд хураавал хурааж болж байна. Үгүй

бол уг нь хууль зүйн техникийнхээ хувьд манай энэ орсон улсууд бол уг нь Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 1-ээс доошгүйг нь сонгуулийн хувьд тэнцүүлэх хуваар л арга зарчмаар сонгоно гэхихвэл энэ чинь яг хууль зүйн хувьд дэлхийн орнуудынхаа стандартаараа яг болчхоод байгаа байхгүй юу.

Яг төдөн гишүүнийг ингээд яг улс төрийнхөө тохиролцоог цаасан дээр ингээд хүчээр буулгах гээд байхаар чинь Үндсэн хуулийнхаа соёл, арга зүйд нь болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд та бид нар чинь улс төрийн тогтолцоогоо янз бүрийн юмнуудаа ингээд шинжлэх ухааных нь арга зүйд нийцүүлэхгүй, өөрийнхөө үгээр ингээд зоож, буух гээд байгаа байхгүй юу. Итгэлцэхгүй байж магадгүй, хулхидаж магадгүй. Гэхдээ энэ Үндсэн хуулийн эрх зүй чинь өөрөө.../минут дуусав/

Н.Энхболд: Шүүмжлэлийг хүлээж авч байна. Жишээ нь сонгуулийн Улсын Их Хурлын 76 гишүүнийг сонгуулийн тойргоос олонхыг төлөөлөх мажоритар тогтолцоогоор, байж байх нь зүйтэй болов уу гэж. За яах вэ, би юу ч гэсэн яриадахъя. 50-ыг нь гэдгийгээ бас нөгөө 50 гишүүнийг тэгээд 50 гишүүнийг улсын хэмжээний сонгуулийн тойргоос гэдэг юм уу ийм маягаар нэг болон бүсчилсэн энэ тэр гээд бүсчилсэн асуудлын тухай бол ерөөсөө яригдаагүй. Анх улс Засгийн газраас санал оруулж ирэхдээ үндсэндээ улс даяараа нэг тойрог байна. Намын жагсаалтаар сонгоно гэсэн ийм л агуулгаар орж ирсэн болохоор бид нар бүсчилсэн энэ тэр гэж задлаагүй юм. Тэгэхээр саяын Сүхбаатар гишүүний хэлсэн зарчмын зөрүүтэй, ялангуяа найруулгын чанартай хойно, урдаа орох жишээ нь зөв л дөө. Нээрээ бид нар бас дутуу л харсан байна. 76 гишүүнийг сонгуулийн тойргоос олонхыг төлөөлөх. 50 гишүүнийг улсын хэмжээний сонгуулийн тойргоос хувь тэнцүүлэх, юу ч гэсэн мажоритар, пропорциональтай нь хураачихъя Сүхээ гишүүн. Тэгээд 2 дахь хэлэлцүүлэг дээр үнэхээр дахиад энэ үг нь

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэрэггүй ээ гэж үзвэл хасчих бүрэн бололцоо байж байгаа.

Тийм яг ерөөсөө маргаан гараад байсан асуудал энэ л дээ. Энэ үгэн дээрээ бас харъя. Арга зарчмаар гэх үү, юу гэх вэ. Дахиад хууль талаас нь бас бусад хуульчидтайгаа зөвлөе, ярья 3 дахь хэлэлцүүлэг дээрээ. Тэгээд одоо бол ямар ч байсан саяын Сүхбаатар гишүүний хэлсний тэр, тэдэн гишүүнийг, тэдэн гишүүнийг гэж зөв болгож засаад, сонгуулийн тойргоос гэж засаад, үүгээрээ хураагаад, дэмжлэг авчихвал, дахиад хэлэлцээд 3 дахь дээрээ заавал өөрчлөх шаардлага байна уу, үгүй юу гэдгээрээ явчихъя. Болж байна уу гишүүд ээ. Сонссон л доо. Үгүй би зүгээр. Сүхбаатар гишүүний хувьд бол ийм байдлаар явахад зөвшөөрч байна гэж ойлголоо шүү. Толгой 2 дахин дохисон. Би тоолсон. Одоо Занданишатар дарга.

Г.Занданишатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ер нь тэгээд 2 хүн толгой дохиод энэ асуудал ишийдчих ёсгүй л дээ. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар чанд баримталж асуудлыг хэлэлцэх ёстой л доо. Тийм учраас хууль санаачлагчийн зүгээс ч гэсэн санал гаргаж байна. 30 минут завсарлаад энэ саналын томъёоллоо янзлахгүй бол ер нь Үндсэн хуульд ингэж тоо заадаг жишиг бараг байхгүй. Манай Үндсэн хуульд 76 гэсэн ганцхан тоо байгаа. Бусад нь дандаа нийт гишүүний 4-ний 1, нийт гишүүний 4-ний 3, нийт гишүүний 3-ны 2, 3-ны 1 гээд ингээд хувьчлаад тооцчихсон тоонууд байгаа.

2 дугаарт энэ 76-г энэ чинь одоо ёстой нөгөө хүн сонгох гэж байгаа биш. 76-г сонгоно. Тойргоос сонгуулийн олонхыг төлөөлөх, тойргоос сонгуулийн олонх гэж, сонгуулийн олонх гэж юуг хэлж байгаа юм. Тэгээд энэ бол найруулгын хувьд болон хууль зүйн техникийн хувьд энийг хэлэлцэж байгаа нь өөрөө асуудал дагуулж болзошгүй учраас завсарлаад, ажлын хэсэг

томъёоллоо нэг мөр болгож орж ирсэн нь дээр.

2 дугаарт нь ер нь бас энэ хууль санаачлагчаас ч оруулж ирэхдээ мажоритар гэж бичээд байгаа юм. Тэгээд мажорити гэдэг үг бол бүх улсын Үндсэн хуульд олонх гэдэг үгээр явдаг. Олонхыг төлөөлөх мажоритар сонгуулийн систем гэж байна. Мажоритар төлөөлөл гэж байна. Олонхыг төлөөлөх гэдэг үг. Үндсэн хуульд олонх, цөөнх гэж 2 үг байдаг юм. Тэгэхээр абсолют мажорити гэх юм бол 50 дээр нэмэх нь 1-ийг хэлдэг. Одоо олон улсын тогтсон нэр, томъёо нь. Монгол хэлэнд яах вэ, олонхыг төлөөлөх гээд суучихсан томъёолол. Гэхдээ хамгийн олон санал авсан аргаар энэ сонгуулийн зарчим гэж бас биш. Ер нь бол яах вэ ингээд ингэж томъёолж болж байгаа юм л даа. Хамгийн олон саналыг төлөөлөх хувь тэнцүүлэх аргаар сонгоно гэсэн ийм томъёолол байж болно. Яах вэ, олонх гэхээр 50 дээр нэмэх нь 1 гэж ойлгогдоод, хожим үл ойлголцол үүснэ гэж үзвэл олонхыг төлөөлөх гэдгээ тайлбарлах хэрэг гарна.

Тийм учраас хамгийн олон санал авсныг л төлөөлөх зарчим гэж ойлгож болно. Яах вэ, гэхдээ олон улсын нэр томъёондоо мажоритар буюу мажорити гэдэг үг чинь ерөөсөө яг энэ Үндсэн хууль хэлэлцэж байх үедээ Үндсэн хуулийн 44-д байх аа даа олонхын энэ тэр гээд явчихсан үгнүүд байдаг юм. Олонх гэдэг үг бол байгаа юм. Тэгэхдээ хамгийн олонх болоогүй бол хамгийн олон суудал авсан нам бусад намд санал тавьж нөгөө Ерөнхий сайдыг сонгох зарчим дээр ийм агуулга байгаа. Тэгэхээр яах вэ, хамгийн олон санал авсныг сонгох, хувь тэнцүүлэх аргаар сонгоно гэсэн ийм агуулгаар өөрчилж болох байх. Хэрэв олонх гэдэг дээр асуудал үүснэ гэвэл. Тийм учраас энэ агуулгаараа өөрчлөлт оруулмаар байна.

Манай Сүхбаатар гишүүн бол туршилагатай, энэ чиглэлээр маш их ажилласан, мэргэшсэн ийм парламентын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хүн учраас энэ гол саналыг хэлж байна. Тэгэхдээ төрийн нийтийн гэдэг чинь бол Чимэд багшийн томьёолол шүү. Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль дээр Чимэд гуай 1994 онд оруулж ирэхдээ төрийн нийтийн гэж оруулж ирсэн тэр Чимэд багшийн үгээр нь авсан үг байгаа юм. Тэрийг бол тэр үед бас Сүхбаатар гишүүн ажиллаж байсан. Энэ таирамд зүгээр хэлчихье. Тэгэхээр энийгээ бол ингээд харьцангуй олонх энэ тэр гэж болохгүй л дээ. Ер нь хамгийн олон санал авсныг төлөөлөх зарчим л байгаа юм. Мажорити гэдгээ абсолют мажорити гэх юм бол 50 дээр нэмэх нь 1 болчихдог. Мажоритар гэдэг бол яах вэ олонхыг төлөөлнө гээд л манай энэ ном сурах бичиг энэ тэр дээр бол тогтсон нэр. Жишээлбэл нэр томьёо тогтоочих юм бол байна шүү дээ. Үндсэн хуульчлаад тогтоочих юм бол тэрийг тэгж ойлгоод явчихна. Унтраалга гэдэг энэ бол уг нь асаалга шүү дээ. Асаадаг. Унтраалга гээд л яриад хэвшчихсэн шиг. Одоо олонхыг төлөөлөх гэж уг нь мажоритар системийг нэрээр дэлхий даяараа тогтчихсон нэр. Тэгээд гадаад үг оруулах нь зохисгүй. Угаасаа мажоритар, мажорити, мажоритар гэдэг үг чинь мажорити гэсэн олонх гэсэн үгнээс л үүссэн үг. Бүр Англи хэлний тодорхойлолтод тийм тоо гэж заачихсан. Тийм учраас Англиар олонх гэж бичсэн, Монголоор олонх гэж бичсэн 2 зарчмын хувьд ялгаагүй байхгүй юу. Гадаад үг хэрэглэхгүй байх нь зүйтэй гэсэн Үндсэн хуулийн ерөнхий зарчим байдаг учраас Үндсэн хууль анх хэлэлцэж байх үед ч гэсэн гадаад үг хэрэглэж болохгүй гэсэн зарчим хэлэлцэж байгаад ганцхан прокурор гэдэг гадаад үг орсон. Тийм учраас энийгээ бол тогтоод, ойлгоод, тайлбарлаад явчхаж болох ийм саналтай. Тэгээд бүр болохгүй бол хамгийн олон саналыг төлөөлөх сонгох аргыг байдлаар хэлж болох байх.

Ингээд ер нь 30 минут завсарлаад томьёоллоо ер нь яг нэгмөсөн болж найруулаад яахгүй бол ингээд толгой дохиод, дохиод шийдчихдэг сүүлд нь тэгээд бас бөөн асуудал гарна.

Н.Энхболд: Пүрэвдорж гишүүн саналаа хэлье.

Б.Пүрэвдорж: Би тэгэхээр би энэ мажоритар гэдэг үг энэ Үндсэн хуульдаа шууд одоо энэ Англи үг ороод явах нь зөв юм уу, буруу юм уу гэдэг дээр гайхаад байна л даа.

1 дүгээрт, мажорити гэдэг чинь бол нэг тооны хагасаас илүүг нь хэлдэг байхгүй юу. Мажорити гэдэг чинь. Хагасаас илүү тоо юм уу, аль эсвэл хувийг хэлдэг. Тэгэхээр энэ дээр жишээ нь одоо энийг гуйвуулаад, өөрөөр хэлбэл ингээд жишээ нь нийт сонгогчдын 50 дээр нэмэх 1 хувийг нь санал авсан хүн тойргоос сонгогдоно гэж ойлгож, тэндээ Үндсэн хуулийн цэц энэ тэр өгөөд явах тийм бололцоог л үүгээр гаргаад өгч байгаа юм уу гэж хараад байгаа юм. Өгч магадгүй. Тийм учраас Занданиатар даргын хэлээд байгаа 30 минутын завсарлага аваад, тодорхой яг хэллэг бүх юмнуудаа сая 76-г сонгоно гэдэг чинь хүнийг сонгох ёстой болохоос тоо сонгох тухай асуудал яг энэ Сүхбаатар гишүүний яриад байгаа зөв байна.

Дээрээс нь тойргоос гэхээр сонгуулийн тойрог гээд ингээд явах нь зүгээр байна. Тийм учраас манай Занданиатар дарга, Сүхбаатар гишүүн 2 бас энэ Үндсэн хуулийн асуудлаар бас нэлээн мэргэшсэн учраас энэ дээр зөв санал гаргаж байна. Тэгээд дээрээс нь мажорити гэдэг чинь ерөөсөө л 100 байлаа гэхэд тэрний олныг нь л хэлдэг байхгүй юу. 50 дээр нэмэх нь 1-ийг л хэлнэ. Гэтэл энийгээ буцаагаад Ховд аймгаас одоо юу гэдэг юм тойргоос сонгогдож байгаа хүнийгээ заавал 50 дээр нэмэх 1 хувийн санал ав гэдэг ийм юм руу тулгачихвал яах юм бэ. Тийм учраас энэ найруулга энэ тэр дээрээ завсарлага аваад, тэгээд ярилцаад түр зуур завсарлага аваад ярилцаад бас энэ дээрээ тодорхой ойлголцлын, дээрээс нь бас мэргэжлийн хүмүүсээс тодорхой мэдээлэл аваад ингээд дахиж ярилцсан нь дээр байх гэж ийм саналтай байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Н.Энхболд: Батсуурь гишүүнийг сонсчихъя. Ямар ч байсан нэрс авсан хүмүүсээ сонсчихъя.

Ж.Батсуурь: Үгүй ээ, нөгөө ажлын хэсэг дээр бүгдээрээ л ингэж орж ирсэн. Тэгээд нээрээ яг уншаад байсан чинь тойргоос сонгуулийн олонхыг гээд тэгэхээр яг одоо энэ хүмүүсийн хэлээд байгаа эргээд сонсогдоод байна л даа. Тэгэхлээр яаж байна вэ гэхээр 2 шатын сонгууль руу түлхчих юм биш байгаа энэ чинь. Ойлголт. Үндсэн хуулийн цэц дээр чинь янз бүрийн маргаанууд бий болдог шүү дээ. Тийм болохоор ингээд бид нар бол тэнд маш тодорхой байна гэж харсан. Яг хэлээд харахаар 76 тойргоос сонгуулийн олонхыг төлөөлөх гэхээр чинь сонгогчдын олонх болоод явчихна. Тийм болохоор юу гэдэг юм бид нарын мажоритар гэж яриад байгаа чинь бол хэдэн хүн нэр дэвшихээс үл хамаараад тэдэн дотроо олонхыг авсныг сонгоё гэж яриад байгаа байхгүй юу. Ярихдаа бол. Тэгээд цаасан дээр буусныг нь харахаар олонхыг гэхээр нийт сонгогчдын олонх болоод явчихна. Тэгээд аль нь ч олонх аваагүй байна гээд 2 шатны сонгууль руу түлхчих гэж байгаа юм шиг ийм бодол төрөөд явчихлаа л даа. Тэгээд найруулга талаас нь харах юм уу. Тэгэхээр олонх биш олон гэвэл болж байна л даа. Олныг ч гэдэг юм уу. Агуулгын хувьд.

Н.Энхболд: Саналууд сонслоо. Найруулгаа янзалж болно. Гэхдээ Их Хурлын дарга завсарлага авъя гэж хууль санаачлагчаас санал гарч байна гэж хэлж байна. Хууль санаачлагчийг сонсоодохъя. Амарбаясгалан сайд. Засгийн газар завсарлага авъя гэж байгаа юм байна гэж ойлголоо. Их Хурлын даргаар дамжуулж хэлж байна гэж ойлголоо. Та саналаа албан ёсоор хэлчих үү.

Д.Амарбаясгалан: Өдрийн мэнд хүргэе. Ажлын хэсгээс орж ирж байгаа саналыг хараад томъёоллын хувьд ойлгомжтой болгохгүй бол эргээд Үндсэн хуульдаа том алдаа гаргах эрсдэл байна уу даа л гэж бидний зүгээс үзээд байна.

Яагаад гэхээр өмнөх өөрчлөлт орох гэж байгаа 21.1 дэх заалтад маань мажоритар болон пропорциональ гэсэн аргачлалын талаар огт дурдаж байгаагүй. Одоо Үндсэн хуулийн 21.1 дээр энэ 2 төрлийн аргачлалыг нэмж оруулах гэж байгаа учраас аргачлалын талаарх ойлголтоо цэгцлээд, нэгтгээд оруулах нь зүйтэй болов уу гээд. Тэгэхээр яах вэ, манай ажлын хэсгийн дэд дарга Нямбаатар сайд Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүний хувьд санал гаргасан байгаа. Хэрэв тэр санал дээр гаргаад шийдэж явж болж байна гэж үзвэл ажлын хэсгийн зүгээс татгалзах зүйлгүй. Боломжгүй байгаа бол ажлын хэсэг түр завсарлаад, асуудал шийдвэл зүгээр байна гэж үзэж байгаа юм.

Яагаад гэхээр олонхын гэдэг ойлголт нь өөрөө бид мажоритар гэдэг үгийг олонхын гэж орчуулаад ирсэн. Гэтэл олонхын гэдэг үгийг сая хэлж байгаа гишүүдийн санал нэгэн адил 50 дээр нэмэх 1 гэдэг ойлголт явчхаж байгаа юм. Энгийнээр хэлбэл өнөөдөр 3 мандаттай мажоритар тойрог дээр өрсөлдөөн болоход олонхын саналыг авсан гишүүд нь ялалт байгуулах болж байна. Тэгэхээр олонхын гэдэг ойлголтоор авах юм бол бүх гишүүд 50 дээр нэмэх 1 хувийн санал авч байж ялалт байгуулдаг болох ёстой л болчхож. Ингэхээр өөрөө энэ сонгуулийн нөхцөл байдал, хүндрэлийн хувьд бол энэ сонгууль хүчин төгөлдөр болохоос эхлүүлээд асар олон хүндрэл, бэрхшээлийг дагуулах талтай юм гэж ингэж бол үзэж байна. Бидний хувьд бол ийм санал байгаа юм. Болдог бол Монгол Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй, Монгол Улсын Их Хурлын сонгуулийг пропорциональ болон мажоритар тогтолцоогоор гэх үү, олонхын болон хувь тэнцүүлсэн аргаар явуулна. Аль нэг аргачлал нь 60-аас дээшгүй хувьтай байна гэж ингэж зааж өгч чадах юм бол энэ илүү ойлгомжтой, илүү мэргэжлийн болох болов уу. Маргаан дагуулахгүй нөхцөл рүү орох болов уу гэсэн ийм саналыг нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хоёрдугаарт, энэ дагаж мөрдөх журмын тухай хуультай холбоотойгоор бидний зүгээс өгөх санал бол анх Засгийн газраас өргөн барьсан саналаар нь явах нь илүү ойлгомжтой болох болов уу. Ердийн горимоор хэрэгжих нөхцөлийг нь 1 дүгээр зүйлээр санал болгож өгсөн. Тэр нь бол 2023 оны гээд он, сар, өдрөө тавиад өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэгдүгээр зүйл. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр батлагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй гэдэг заалтыг оруулж өгсөн байгаа юм. Энэ нь илүү ойлгомжтой, тодорхой болох болов уу. Ажлын хэсгээс оруулж ирсэн саналыг унших юм бол магадгүй ээлжит бусын ч юм уу тиймэрхүү агуулга уншигдаж болзошгүй байгаа учраас үүнээс болгоомжилж байгаа.

2 дугаарт нь бол батлагдсанаар ердийн горимоор хэрэгжээд явах нөхцөлийг хангах нь зүйтэй болов уу гэсэн ийм саналтай байна.

Н.Энхболд: Саналуудыг сонслоо. 2 гарц байна цаашаа явах. Ер нь бид нар 1 л юмыг тойруулаад яриад байгаа шүү дээ. Маш товчхоноор хэлбэл 126 гишүүнтэй байя. Маш тодорхой хэлбэл 76-г нь тойргоос, 50-ыг нь жагсаалтаар. Ийм л юмыг тойруулаад яаж зөв томьёолох вэ, яаж буруу ойлгогдохооргүй юм хийх вэ гэсэн тийм л юм ярьж байгаа. Зарчим маань бол нэг байгаа. Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр л бид нар ажилласан Амарбаясгалан дарга аа. Мажоритар гэдэг үгийг Засгийн газар юу гэж ойлгож оруулж ирсэн байна. Бид яг тэр байдлаар ойлгоод л сонгуульд хэдэн хүн оролцоно, хэдэн нэр дэвшигч байна. Хэн нь хамгийн олон санал авсан байна тэр нь сонгогддог тогтолцоог бид нар одоо болтол мажоритар гэж явж, нэрлэж ирсэн. Янз бүрээр нэрлэж ирсэн. Олонхын төлөөлөх зарчим ч гэж нэрлэж ирсэн. Мажоритар ч гэж нэрлэсэн. Энийг тойруулаад л ингээд ярьж байгаа.

Тэгэхээр одоо л заалт юм чинь тоо, танхим тэгээд тойргийн тодорхойлолт энэ юмнуудаа ажлын хэсэгт засаж янзлах үүрэг өгөөд, саналаа хураагаад хуралдаа оруулах нэг боломж байна. Эсвэл түр зуур завсарлаад, дахиад энийгээ үргэлжлүүлээд ярих ийм боломж байна. Алийг нь л бол алийг нь сонгоход бэлэн байна. Горимын санал хурааж болж байна. Их Хурлын гишүүн, Их Хурлын дарга Занданшатарын гаргасан саналын дагуу түр завсарлаад томьёолуудаа дахиад хараадахъя. Гэхдээ үндсэн тохирсон зүйлүүдээ бол хөдөлгөхгүй гэж. Тэгээд дахиад ороод ирэхээр нь дахиад бас нэг өөр юм гарч ирээд бас нэг ойлголтын тухай юм яривал их л олон дахин л байх хэрэг байх болов уу даа. Гэхдээ яах вэ, ямар ч байсан сая энд гарсан саналуудын дагуу хэдүүлээ яриад аль алинаар нь шийдэж болж байна. Би бол горимын санал хураалга гээж бодож байна. Олон санал гараад байна шүү дээ. Янз бүрийн хоорондоо зөрчилтэй. Хуучин ойлгосон юмаа буруу ярьж байсан юм шиг ч тайлбарууд гарч байна. Санал гаргаснаараа Занданшатар дарга та үг хэлэх үү.

Г.Занданшатар: 15 цагаас чуулган эхэлнэ. Тэгэхээр юу байна л даа. Ер нь бол нухацтай хандах нь зөв л дөө. Энэ чинь ердийн хууль хэлэлцэж байгаа биш. Тэгэхээр харьцангуй олонх гэхээр абсолют мажорити болоод байгаа юм тэр саналууд. Тэгэхээр энийг бас нухацтай үзээд ер нь ийм горим байж болж байна. Зарчмаар нь санал хураалгаад параллель зэрэгцүүлсэн аргаар сонгууль явуулах юм байна. Тоо энэ тэр гэсэн үндсэн дээр өөр санал байхгүй гэж үзвэл гишүүд зарчмынх нь хувьд санал хураачхаад найруулгыг нь ажлын хэсэг ахиж чуулганд маргааш оруулахдаа найруулгаа янзлаад ороод ир гэсэн юм. 30 минутад амжихгүй байж магадгүй. Найруулгаа янзлаад, ажлын хэсэгт чиглэл өгөөд, тэгээд зарчмаар нь, агуулга нь ийм агуулгаар тохиръё. Тэгээд найруулгаа ажлын хэсэг ажиллаад маргааш чуулганд орж ирье.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Н.Энхболд: Ажлын хэсэг болно болно. Тэгж болно. Би сая 2 гарц байна гэж ярьсан шүү дээ. Саяын Занданшатар даргын хэлсний дагуу ойлголтууд нэг байна. Яаж зөв томъёолох вэ гэсэн л асуудал байна шүү дээ. Нэлээн нарийн томъёолох хэрэг гарах байх. Та нар чимээгүй бай даа. Хэрэв ингэж яривал их нарийн томъёолох хэрэг гарах байх. Урьд нь бид нар ерөөсөө хийж байгаагүй болохоор. Тэгээд Үндсэн хуульд суучихвал цаашидаа нэг мөсөн ойлголт болоод явах байх. Хамгийн олон санал авсныг гэдэг үгийг хамгийн цөөхөн үгээр илэрхийлэх тийм л үг олохыг бодно доо. Жишээ нь олонхыг төлөөлөх гэдэг дээр бол тэгээд ярьж байгаад энийгээ зөвхөн ажлын хэсгийн хүрээнд биш хүмүүстэйгээ санал солилцъё. Тэгэх үү.

Тэгэхээр одоо олонхын гэхээр чинь зарим хүмүүс. Саналаа хураачихъя тэгэх үү. Тэгвэл саяынхаа ойлголтоороо саналаа хураачаад, томъёоллуудаа жигдлэх юмаа зөвхөн ажлын хэсгийн хүрээнд биш бусад дотроо санал авч ярьж байгаад маргааш хуралд орохоосоо өмнө жигдлээд оръё гээд санал хураах уу Занданшатар дарга аа, та юу гэж бодож байна. Тийм л дээ. Тэр ойлгомжтой. Би түрүүн уншсан шүү дээ. Нэг танхимтай байна. Нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Далан зургааг нь зөв буруу ямар ч тодорхойлж байсан байсан хуучин ойлголтоороо хамгийн олон санал авсан хүн тойргоос сонгогдоно. Үлдсэн нь жагсаалтаар сонгогдоно гэсэн ийм үндсэн агуулгатай л заалт байгаа шүү дээ. Энийгээ дэмжчихвэл нэр томъёо дээрээ, томъёолол дээрээ ажиллаж хэдүүлээ тэгэх үү. Саяынхаар санал хураая. Бэлэн үү гишүүд. Санал хураалаа шүү.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг зарчмын хувьд дэмжээд, нэр томъёоны хувьд цэгцэлж, дахин танилцуулаад яриад чуулганд оруулъя гэсэн томъёоллоор санал хураая.

Баярлалаа. Нэг дэх удаагийн санал хураалт 80 хувиар дэмжлээ.

Одоо 2 дахь удаа саяын томъёоллоороо санал хураалт явуулна. Санал хураалт.

Мөн 80 хувиар асуудал зарчмын хувьд шийдэгдлээ. Ажлын хэсэг, бусад гишүүд оролцоод томъёолол дээрээ хэдүүлээ ажиллая. 2 удаа санал хураалаа.

Нэгэнт ингээд юу яачихаар одоо гишүүдээс ирсэн санал хураалтаар хураана. Танилцуулчих уу. Танилцуулсан нь зөв байх.

Пүрэвдорж гишүүнээс нэг танхимтай, ерэн найман гишүүнтэй гэсэн агуулгатай, жаран наймыг тойргоос гучийг нь хувь тэнцүүлсэн тогтолцоогоор гэсэн байна. Саяын санал дэмжигдсэн учраас энийг санал хураах шаардлага байхгүй.

Сүхбаатар гишүүний санал. Нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй, гуравны нэгээс доошгүй нь сонгуулийн хувь тэнцүүлж хуваарилах арга, зарчмаар сонгоно гэсэн ийм найруулгын тал дээрээ ажиллаад явъя.

Нямбаатар гишүүнээс ирсэн санал байна. Төслийн 1 дүгээр зүйл буюу 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах гээд нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй, далан зургааг нь сонгуулийн харьцангуй олонхын саналаар үгийн зөрүү байна. Сонгуулийн тойргоос харьцангуй олонхын саналаар тавин гишүүнийг хувь тэнцүүлсэн аргаар сонгоно гэсэн саяынхтай ижилхэн гэхдээ үг үсэг дээр ажиллах асуудлаа бид нар шийдсэн учраас тэр хүрээндээ эргээд нэгтгэчихье томъёоллуудаа.

Ингээд сая ажлын хэсгээс оруулсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн ажлын хэсгээс оруулсан саналууд, гишүүдээс гарсан зарчмын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зөрүүтэй саналуудаар санал хурааж дууссан. Одоо Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор бүхлээр нь дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны санал хураалтад 15 гишүүн орж, 13 гишүүн дэмжиж, 86.7 хувиар Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хэлэлцүүлэгт оруулж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлье гэсэн санал дэмжигдлээ. 1 дүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа. Гишүүддээ баярлалаа. Санал, дүгнэлтийг би чуулганы хуралдаанд танилцуулчихъя.

15.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Асуудал хэлэлцэж байгаатай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг, албан тушаалтнууд хэвээрээ.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.1-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан. Одоо хуулиа, төслөө зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух гишүүд нэрсээ өгье. Тараачихсан байгаа болно. Асуулт асуучих. Асуулт асуунгаа хэлчих. Асуулт байхгүй бол саналынхаа томъёолол дээр хувиа хэлээд явчихна. Асуулт байхгүй юу. Асуулт байхгүй юм байна шүү. Одоо ингээд нөгөө хуулиудынхаа заалтууд дээр хэлээд явчихъя гэсэн. Яг дэгээрээ бол асуулт л юм байна лээ. Тэгээд одоо үг хэлж болно. Би төслөө эхнээс нь уншаад танилцуулъя. Хэдийгээр тараасан ч гэсэн. Тэгээд энэ

бол юун дээрээ зөрүүтэй байгаа юм гэдгийг нь хэлчихье. Тэгээд та Засгийн газраа төлөөлөөд байр сууриа илэрхийлж болно.

2 дахь асуудалдаа орж хэлэлцэж эхэлж байна. Засгийн газраас оруулж ирсэн төслийг би та бүхэнд уншаад танилцуулчихъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих дүрмийн тухай Монгол Улсын хууль.

1 дүгээр зүйл тэдэн оны тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн 1 дүгээр зүйл.

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй гэсэн нэг заалт байгаа.

2 дугаар заалт нь тэдэн оны тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны тэдэн сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм төсөл орж ирсэн байгаа.

Энийг бид нар ажлын хэсэг дээр ярьж байгаад дараах байдлаар томъёолсон.

1 дүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3-д

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Би дараа нь тайлбар хэлнэ.

2-т, хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална гэж.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг 2 хуваагаад 3, 4 дүгээр зүйл болгоод доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3 дугаар зүйл. 2023 оны тэдэн сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн баталж мөрдөх хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Энэ бол дээрх орж ирсэн заалтын эхний хувилбар. Үндсэндээ яг тэр утгаараа чигээрээ явж байгаа.

Дараа нь 4 дүгээр заалт болгоод Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлын 2024 оны 6 сарын 1-ний дотор хийж дуусгана гэсэн заалт нэмж оруулсан. Нэгний дотор энэ яагаад оруулсан гэхээр 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэх ажлууд хууль тогтоомж бусад хууль тогтоомжид нийцүүлэх ажлууд зарим нь одоо болтол хийгдээгүй байгаа учраас хугацаа тогтоохгүй байгаа нь өөрөө бас асуудлыг хойш нь тавих шаардлагатай асуудлуудыг ишийдэхгүй байх сонирхлыг өдөөх гэх мэтчилэн нөхцөл байдал байгаа юм болов уу гэж үзээд, тодорхой хугацааны дотор Үндсэн хуульд нийцүүлээд бүх шаардлагатай нийцүүлэх ажлуудыг хийж дуусгая гэж ингэж оруулсан байж байгаа. Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан

өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй гэсэн 5 дугаар зүйл нэмээд 3 дугаар зүйлээ 6 дугаар зүйлийн болгож өөрчлөх гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал орж байгаа юм.

Би зүгээр гишүүдийг үг хэлэхээс өмнө бас нэг тайлбар хэлчихье. Урьд өмнө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ийм шилжих журмын тухай хууль гэж гараад, хууль хүчин төгөлдөр болох хугацаанууд мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн энэ өөрчлөлт бол энэ хууль нь өөрөө Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй адилхан хүчинтэй гэсэн ийм заалтыг оруулж өгч явж ирсэн юм байна лээ. Тэгээд энэ бол өөрөө бас яг хуулийн зохицуулалтаар одоо болтол бүрэн гүйцэд шийдэгдээгүй, зохицуулагдаагүй, маргаантай цаашидаа боловсронгуй болгох ёстой асуудал юм билээ.

Тухайлбал Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлтийг эс үгүй бол тэгж дагаж мөрдөх журмыг нь ердийн хуулиар хийх үү, үгүй юү гэдэг асуудал байгаад байгаа юм байна лээ. Тэгэхдээ энийг зохицуулаад ирсэн арга нь 1 дүгээрт саяын бид нарын хэлснээр энэ хуульдаа адил хүчинтэй гэж оруулах, 2 дугаарт нь ерөөсөө Үндсэн хуулийн хавсралт гэж гаргаад, нэрлэхийгээ шилжих журмын тухай гэж нэрлээд явуулах ийм хоёр арга байна гэж хуульчид үзсэн. Тэгээд үүний дагуу бид нар ямар ч байсан энд 1 дүгээр байдлаар томъёолоод гишүүдэд тараачихсан байгаа. Хавсралт маягаар больё гэвэл танилцуулах 2 дугаар хувилбар бэлэн байгаа.

Ажлын хэсэг дээр бол бид нар нэгээрээ тохирсон юм. Энэ дээр бас гишүүдийг саналаа хэлье. Яаж явах вэ гэдгээ ярьцаая. Одоо томъёолтой холбогдуулаад ажлын хэсгийн саналтай холбогдуулаад асуух, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Нямбаатар сайдаа одоо нэрээ өгцгөөж болно. Бямбацогт гишүүн, Нямбаатар гишүүн, Занданшатар дарга, энэ 3 хүнээр тасаллаа. Бямбацогт гишүүний.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

С.Бямбацогт: Энэ ажлын хэсгээс оруулж ирж байгаа энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмье гэж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гэдэг маань хэзээнээс хүчин төгөлдөр болох вэ? Хэзээ яаж мөрдөгдөж эхлэх вэ гэж байгаа юм бол? Энэний цаана өөр ямар нэгэн одоо юу гэдэг юм бас агуулга юм байгаа юу, байхгүй юу?

Н.Энхболд: Байхгүй тийм. Болчихсон уу?

С.Бямбацогт: Тийм.

Н.Энхболд: Энэ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль гэж энэ чинь юу байна шүү дээ, эд эдний оруулж ирсэн юу байна шүү дээ. Үгүй ээ үгүй чи нөгөө нэг өөрчилсөн саналынхаа цаад юуг нь. Биш ээ биш. Энэ хүчин төгөлдөр болох заалт өөр бусад хууль дээр яасан. Чи түүрүүн надаа үзүүлээд байсан тэрийгээ. Чи тэр юугаа гаргаад ир. Ер нь бол ийм Бямбацогт гишүүнээ одоо ингээд бид нар хуулиа баталчихлаа гэж бодъё тийм ээ. Хуулиараа бол зохицуулалт нь 2 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргэх ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийн өөрчлөлтийг дэмжиж байвал 3 хоногийн дотор баталгаажуулаад гарын үсэг зураад баталгаажуулаад хариу өгөх ёстой. Хориг тавина гэвэл долоо хоногийн хугацаанд багтааж, тэрийгээ үндэслэлээ гаргаад ирүүлэх ёстой юм байна лээ.

Ингээд өөрөөр хэлбэл, бид нар хэзээ батална, тэрнээс хойш үндсэндээ 10 хоногийн дотор энэ хууль хүчин төгөлдөр Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болоод явах ийм л зохицуулалттай юм байна лээ. Дөнгөж сая чам дээр байсан даа. Хадгална гэсэн үгтэй заалт чинь хаана байна вэ? Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тэгвэл одоо Улсын Их Хурал баталснаас хойших 57 гишүүнээр батална шүү дээ тийм ээ. Тэрнээс биш 10 хоногийн дотор үндсэндээ хүчин төгөлдөр болох юм байна гэсэн гэж агуулгаар гэж ойлголоо. Өөрөөр хэлэх юм бол.../үг тасрав/

Н.Энхболд: Би дахиад хуулийнх нь заалтыг нэмээд уншаадахъя. Тийм.

С.Бямбацогт: Тэгэхээр үндсэндээ бол Их Хурал 57 гишүүнээр одоо эцсийн хэлэлцүүлэг хийгээд баталснаас хойш 10 хоногийн дараагаас эхлээд Үндсэн хуулийг хүчин төгөлдөр болж эхлэх нь. Тэгээд энэтэй заавал, 4 дүгээр зүйл дээр ингэж байгаа юм л даа. Бас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурал 24 оны 6 дугаар сарын 1-ний дотор хийж дуусгана гээд. Тэгэхээр энэнээс чинь залгаад нөгөө Сонгуулийн хууль яригдана шүү дээ бас.

Н.Энхболд: Тэгнэ.

С.Бямбацогт: Сонгууль болохоос нэг жилийн өмнө Сонгуулийн тухай хуулийг баталсан байх Үндсэн хуулийн заалттай болчихсон. Тэгэхээр бид нар энэ Сонгуулийн хуулийг өөрөөр хэлэх юм бол бас ойрын үед л батлахгүй бол болохгүй. Гэтэл одоо 24 оны 6 сарын 1 дотор одоо юу Үндсэн хуульд нийцүүлэх.

Н.Энхболд: Үгүй ээ, энэ ерөөсөө бүх хуулиудыг хэлж байгаа юм. Сонгуулийн хуулийг бол бид нар ерөөсөө энэ Үндсэн хууль батлагдчихвал 6 сарын хамгийн цаад тал нь гэхэд 20-ны дотор баталсан байх ёстой. Яагаад энэ заалт орсон юм бэ гэхээр энэ заалт орохгүй болохоор бүүр ерөөсөө ямар ч зохицуулалтгүй болчихоод байгаа юм. Энэ удаагийн чуулганы хуралдаанаар Сонгуулийн хууль, Намын хууль эд нарыг бүгдийг нь батална гээд орчихсон. Одоо хэлэлцүүлгүүд нь эхлээд явж байгаа. Тийм учраас хэчнээн түргэн батлах тусмаа л төчнөөн сайн. Зүгээр Үндсэн хууль энэ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дагаад тэр, тэр хуулиудыг өөрчил гэж заах нь бол бас зохисгүй болов уу гэж бодож байгаа. Тэртээ тэргүй бүгд мэдэж байгаа, ойлгож байгаа, шаардлагатайг нь хүлээн зөвшөөрч байгаа учраас Сонгуулийн хууль, Намын хуулиуд бол энэ чуулганы хугацаанд.

Намынх бол хэлж мэдэхгүй байна. Сонгуулийн хууль ямар ч байсан 6 сарын 20-ны дотор батлахгүй бол нөгөө таны саяын хэлдэг жилийн дотор батлагдсан байх ёстой юм зөрчигдөнө. Тэгэхээр бид нар Үндсэн хуулиа баталж энийгээ баталчихвал заавал хийхээс өөр аргагүй ийм байж байгаа хуулиар заагдчихсан. Тэгэхээр бусад хуулиуд хоцорчхоод байгаа учраас хийгдэхгүй байгаа учраас жишээ нь 19 онд батлагдсан Үндсэн хуулиар Намын тухай бусад хуулиудад өөрчлөлт орох ёстой шүү дээ. Одоо болтол ороогүй яваад байгаа болохоор тэрийг нь л одоо багтааж хийнэ шүү гэдэг агуулгаар яг энэ заалтыг бол тэгж оруулсан юм. Түүнээс Сонгуулийн хууль хугацаандаа заавал явна. Тийм. Тэгээд сая таны түрүүчийн хэлсэн асуусан асуулт дээр бол Үндсэн хуульд нэмэлт оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3 дээр Ерөнхийлөгч хуулийн 1.16-д заасны дагуу Ерөнхийлөгчид биечлэн хүргүүлсний дараа танилцуулснаас хойш ажлын 3 өдрийн дотор тэдэн оны тэдэн сарын тэдний өдөр энэ хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн эх мөн гээд гарын үсэг зураад, тамга дараад баталгаажуулаад, тэгээд хадгалчхаж байгаа юм. Тэгээд хүчин төгөлдөр болно гэсэн үг. Угаасаа хууль дээр байгаа зохицуулалт нь энэ юм.

Тэгээд бид нар зүгээр энэ 16.3 гэдгээр нь бичих үү, эсхүл ерөнхий байдлаар гэдгийг нь ярьж байгаад л ерөөсөө Журмын тухай хуулийн заасан зохицуулалтын дагуу хүчин төгөлдөр болно гэсэн санаагаар биччихвэл бас болох юм уу гэсэн ийм л бодолтой байна. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би яг нөгөө ажлын хэсэг дээр энэ нөгөө Үндсэн

хуулийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх дээр шилжих журмын тухай юуг ярьж байхад би түрүүлээд нөгөө гараад явчихсан юм. Тэгээд би энэ дээр бол нэг ийм санал байна. Байнгын хорооны дарга, гишүүдийг энэ ЗГ-аас өргөн барьсан төслөөр нь энэ дагаж мөрдөх шилжих журмын хуулийг авч үлдвэл яасан юм бэ? Энэ ингээд 6, 5 санал хураах гээд байна л даа. Энд ерөөсөө бүх агуулга багтчихаад байгаа юм.

Нэгд нь 2023 оны ... дугаар сарын ... дугаар өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн 1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Их Хуралд хамаарахгүй гэдэг энэ агуулга чинь энэ доор бичигдчихээд байгаа юм.

2 дахь санаа юу вэ гэхээр 2 дугаар зүйл. 2023 оны ... дугаар сарын ... дугаар өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана. Энэ яасан бэ гэхээр одоо Энхболд дарга санаж байгаа шүү дээ 2010, 2020 оны 1 дүгээр тогтоол байдаг юм шүү дээ Их хурлын нөгөө хувиар батлах. 2 билүү тийм ээ? Дугаар 2 дугаар тогтоолоор бид нар энэ үе шаттайгаар хууль батлах ажлыг хийхэд энэ одоо зарчмын зөрүүтэй саналаар бол шууд ингээд тулгачхаж байгаа байхгүй юу.

Бид нар өөрсдөө энэ хэрвээ өөрчлөлт батлагдсан тохиолдолд Их Хурал хувиараа гаргаад боломжит хугацаандаа батлаад явъя. Мэдээж хэрэг цаг хугацаатай Сонгуулийн хууль энэ тэрийг бол цаг хугацаанд нь тааруулаад нийцүүлээд явъя. Энэ хууль батлагдангуут хэрвээ батлагдсан

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тохиолдолд 1 дүгээрт Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулна. 2 дугаарт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулна. Сонгуулийн тухай хуульд шинээр батлах шаардлагууд гарна. Тэгэхээр одоогийн энэ зарчмын зөрүүтэй саналаар одоо ажлын хэсэг дээр ажилласан энэ агуулгаар болох юм бол бид нар энэ дээр хувь 2024 оны 6 дугаар сарын 1-ний дотор хийж дуусга л гэдэг хугацаа өгч байгаа байхгүй юу. Нэг жилийн хугацаа өгч байна. Гэтэл бид нар энэ одоогийн төслийн өргөн барьсан санаа бол Улсын Их Хурал өөрөө Занданишатар даргын гарын үсэгтэй 2020 оны 02 дугаар тогтоолоор хуваариа батлаад, тэр баталсан хуваарийнхаа дагуу л батлагдчихна. Тэгэхээр төсөл өөрөө илүү ойлгомжтой бөгөөд цэгцтэй 3 заалттай байгаа.

3 дахь заалт нь болохоор энэхүү хуулийг 2023 оны ... дугаар сарын ... дугаар өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө гэж байгаа юм. ЗГ сая Амарбаясгалан дарга дээр бид нар ямар яриа ярьсан бэ гэвэл ер нь энэ хүчин төгөлдөр болох хугацаагаа шууд энэ дээрээ заачихъя. Заасан хугацаа нь 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байя. Бас тэр юу өдөр судар юмаа бас харах нэг хэрэг байгаа шүү дээ. Тэр утгаараа.

2 дугаарт, та бүхний боловсруулсан энэ ажлын хэсгийн яг эхний заалт байна шүү дээ. Энэ манай Байнгын хорооны зөвлөхүүд энэ тэр харах хэрэгтэй л дээ. Энэ 16.3 гэдэг заалт чинь өөрөө Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн эхийг хадгалах харилцаа байхгүй юу. Хадгалах харилцаа. Өөрөөр хэлбэл эх дээр гарын үсэг зураад, Ерөнхийлөгч өөрөө хадгалах хугацааг зохицуулалтыг л 16.3 гэж байгаа байхгүй юу. Тэрнээс биш Үндсэн хууль өөрөө үйлчлэх хугацаагаа тээж энэ Дагаж мөрдөх шилжих журмын хуулиараа шууд заасан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч уг эх дээр гарын үсэг зураад, хадгалах

харилцаа гэдэг чинь өөр 2 харилцааг нийлүүлээд 16.3-ыг эшлээд авчихсан нь өөрөө буруу байна. Тийм учраас би та хэдийг сайн хараад энэ ЗГ-аас өргөн барьсан төслөөр.../минут дуусае/

Н.Энхболд: Үгүй ээ, энэ л хугацаа нь шүү дээ. Хэзээ батлагдана. 2 өөр бол ойлголт яваад байх шиг байна. Нэг нь батлагдах, нөгөөдөх нь хүчин төгөлдөр болох тухай асуудал. Тэрийг орхичихъё, тэрийг орхичихъё, тэрийг засаж болно. Зөвхөн хадгалах хугацаа гэж үзэж байгаа бол тэрийг авахгүй байж болно. Хүргүүлнэ гэж байгаа юм, хүргүүлнэ гэж байгаа юм. Тийм. Гарын зурж баталгаажуулна гэдэг чинь Ерөнхийлөгч гарын үсэг зурахгүй, баталгаажуулахгүй бол тэр болтол хүчин төгөлдөр биш л гэсэн үг байхгүй юу даа. Тэгээд зөвхөн хадгалах тухай асуудал биш гэж ойлгосон ажлын хэсэг дээр бид нар ярихдаа тийм. Занданишатар даргыг үг хэлүүлчхээд, дараа нь микрофонд наад юмнуудаа ярьчихаарай. Занданишатар дарга.

Г.Занданишатар: Энэ 3 санал байна. Энэ Нямбаатар сайдын хэлж байгаад бас үндэслэлтэй ийм маргаан үүсэж болзошгүй учраас тэгэхдээ энэ 16.4-тэй бол Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан эхийг Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдэнэ гэж байгаа юм. Тэгээд үндсэндээ хүчин төгөлдөр болох агуулга байгаа юм. Тэгэхдээ 16.3-ыг эшилдэг нь хууль зүйн техникийн хувьд бас алдаатай маргаантай болж магадгүй. Тэгэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол ингэж томъёолсон юм байна лээ. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь уг эхийг Монгол Улсын Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гээд. Ингээд найруулгаа явчихвал заавал 16.3-аа ч үндэслэххээж байна, 16.4-өө ч хийчихнэ.

Бас энэний дараа нөгөө Сонгуулийн хууль хэлэлцэнэ хугацааны шахуу энэ тэр байдлаа бодоод ингээд өдөр судар хараад тооцоод үзэхээр ингэж найруулбал 16.3-

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ынхаа ч агуулгыг бичээд авчихна. Яг 16.3-ыг Дагаж мөрдөх журмын тухай хууль дээр эшлэх нь бас ийм маргаантай асуудал үүсгэж болно. Тийм учраас Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гээд тодорхой биччихвэл яасан юм бэ гэж.

Хоёрдугаарх нь тэр Нямбаатар сайдын тэр юу зөв байгаа юм. 24 оны 6 сарын 1 хүртэл энэ нийгэмд ч гэсэн нэг буруу ойлголт төрөхөөр. Тэгэхээр төслөөрөө төслийн 2 дугаар зүйл буюу энэ санал хураалтын 4 дүгээр зүйлийг саналын томъёоллын 4 дүгээр зүйлийг бол ЗГ-ын өргөн мэдүүлснээр аваад явчихсан нь зөв байх. Нийцүүлэх ажил чинь энэ хуультай тогтоомжтой, Үндсэн хуультай уялдаад нөгөө нэг жилийн өмнөх энэ тэр гээд бусад юмнууд гарах учраас буруу ойлголт өгч болзошгүй учраас ЗГ-ын төслөөрөө аваад явчихсан нь дээр байх гэж бодож байна.

3 дугаарт нь тэр юу их жоохон төсөл дээр ч байгаа, энэ дээр ч байгаа тэр 1 дүгээр зүйл төслийн 1 дүгээр зүйл буюу саналын томъёоллын 2 дугаар зүйл Улсын Их Хурал Бүрэн эрхээ хэвээр хадгална гэдэг маань Үндсэн хуульд угаасаа 4 жилийн хугацаатай байна энэ тэр гээд ингээд байгаа шүү дээ. Тийм учраас энэ заалт бараг хэрэг байна уу, үгүй юү? 24 оны ээлжит, 24 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжих хүртэл хугацаанд 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал бүрэн эрхээ хэвээр хадгална гэдэг чинь нэг тийм, тэгээд төслийн заалт хоёр чинь нэг, Үндсэн хуулийн зөрчил болж болзошгүй тийм. 4 жилийн хугацаатай байна энэ тэр гээд ингээд юутай байгаа учраас. Тэгэхээр энэ, яах вэ хүчин төгөлдөр болох асуудал бол энэ Засгийн газрынхаар явах юм бол хойшилчхож магадгүй эрсдэл байна.

Тэгэхээр бид нар чинь жишээлбэл яах вэ өдөр тооцоод үзэхээр 6 сарын 7 гэхэд нотлон баталгаажуулчихсан байвал

Сонгуулийн хуулиа бид нар чинь 2 хэлэлцүүлэг хийх хугацаа, нэг жилийн өмнө Сонгуулийн хууль батална энэ тэр гэдэг ингэж тооцоод Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно гээд тодорхой заачихсан нь зөв байх гэж бодож байна. Тэгэхгүй бол нөгөө хэвлэн ердийн журмаар явах юм бол энэ хугацааны алдагдалд орох эрсдэл байгаа учраас.

Н.Энхболд: Тэр нэг бүрэн эрхээ хэвээр хадгална гэж ажлын хэсгээс томъёолсон, Улсын Их Хуралд хамаарахгүй гэж томъёолсон 2 бол цаад утгаараа бол яг адилхан. Тэгэхдээ нөгөө зөвшилцөх үед намуудаас гарсан янз бүрийн санал, бас биедээ итгэх, итгэхгүйн тухай асуудал энэ бүх юмнуудыг ярьж байгаад оруулсан юм байна лээ шүү. Үүнийг бас тийм ерөөсөө л тийм шүү дээ. Тэгээд одоо жишээ нь энийг нь хэрэггүй гээд хасчихаар яг л одоо алхам алхмаар. Бодоцгооё. Ер нь байна шүү дээ, ер нь энэ ерөөсөө л энэ 3 санаа л байгаа л даа бас л. Бид нар нэмж оруулсан юм байхгүй.

Нэг анхаармаар зүйл бол энэ Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил гэдэг үгээ энд ингээд оруулах нь заавал шаардлагатай гээд манай Тамгын газар хуульчид, тэгнэ, тэгнэ хэлнэ, үзээд байгаа юм. Тэгээд энэ 19 онд орохдоо бас яг ийм үгтэй явсан юм байна лээ. Яг ийм үгтэй заалт орсон юм байна лээ. Үүнийг бол ингээд явуулчхаж болно. Урьд нь ингээд гарчихсан юм гээд. Бүүр одоо хэрвээ маргаан элдэв янзын юм гарна гэвэл Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хавсралт гэдэг маягаар яваад нөгөөдөх нь явах ийм 2 дахь боломж байгаа гэж яриад байгаа. Тэгэхээр яахаа одоо бид нар бол ажлын хэсгээс ингэж боловсруулаад л оруулчихсан юм. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Бид нэг зүйл дээр Занданиатар даргаа хэдүүлээ нэг зүйл дээр аягүй том хэдүүлээ төөрөлдөцгөөгөөд байгаа юм. Батлах, ёсчлох гэдэг 2 өөр үг байхгүй юу. Үндсэн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.8 дээр Улсын Их Хурлын нийт гишүүдийн $\frac{3}{4}$, түүнээс дээш хувь нь батлах санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдсанд тооцож нийтэд зарлан мэдээлнэ гэж байгаа байхгүй юу. Тийм 15.8. Тэгэхээр ЗГ-ын төсөл чинь 15.8-ын үндсэн агуулгыг шингээж байгаа байхгүй юу. Бид ингээд явсаар байгаад 6 сарын 3-нд уу, 5-нд уу, 7-нд хамгийн сүүлийн санал хураалтаа хийж батлагдсан тэр өдрийг л Үндсэн хууль баталсан өдөр гэж байгаа байхгүй юу. Баталсан өдөр.

Батлагдсаны дараа Үндсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгч ёсчилсноор цаашаагаа нийт Төрийн мэдээлэлд тэр хэвлэгдээд ингээд үйлчилж эхлэх хугацаа гарч ирэх байхгүй юу. Тэгэхээр би Үндсэн хуулийн Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг ЗГ-аас өргөн мэдүүлсэн энэ 3 заалт бүхий төслөөр нь дэмжээд өгөөч. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлах эрх бүхий субъект биш. Батлах эрх бүхий субъект нь бид. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийнхаа хэлэлцүүлгүүдийг хийж дууссан тэр өдрөөр тэр өдөр батлагдсан өдөр нь болж байгаа юм. 92 оны Үндсэн хууль ч мөн тэгж явсан. Энэ батлагдсаны дараа Ерөнхийлөгчийн хориг тавих хоригийн хугацаа орж ирнэ. Хоригийн хугацаа дууссаны дараа Ерөнхийлөгчийн ёсчлох, үзэглэх, ёсчлох харилцаа үүснэ. Батлах, ёсчлох хоёрыгоо хэдүүлээ хольж хутгаж энэ Журмын тухай хууль дээр оруулж ирээд байна л гэж би Шилжих журмын хууль дээр оруулж ирээд байна. Тэрийг Улсын Их Хурлын энэ Үндсэн хуулийг нэмэлт оруулах энэ хуваарийн дагуу бид нар хамгийн сүүлийн санал хураасан өдрөөрөө Үндсэн хууль батлагдана. Ёсчлогдсон өдрөөс хойш уг Үндсэн хууль үйлчлээд, Төрийн мэдээлэлд нийтлэгдээд ингээд хүчин төгөлдөр үйлчлээд явна гэсэн санааг хэлэх гээд байгаа юм.

Тийм учраас энэ Засгийн газрын оруулж ирсэн төслийг Байнгын хорооны гишүүдийг төслөөр нь дэмжиж өгөхийг л та бүхнээс хүсэж байгаа юм. 15.8 дээр маш тодорхой ингээд зохицуулалтыг нь заачихсан байгаа. Бид нар бас Хэрэг эрхлэх газар дээр сая ажлын хэсэг дээр ярьсан Амарбаясгалан даргаа тийм ээ. Та тэгэхээр нэмж хэлбэл.

Н.Энхболд: Занданшатар дарга.

Г.Занданшатар: Нямбаатар сайдын 15.8-аар бол ингээд баталсанд батлагдсанд тооцож нийтэд зарлан мэдээлнэ гэж байгаа. 16.4-д ер нь яах вэ ёсчилно гэсэн үг бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль дээр байхгүй. Ерөнхийлөгчийн нотлон баталгаажуулсан уг эхийг Үндсэн хуульд байршуулж, Төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эхэд тооцно гэж ийм агуулга. Тийм учраас нотлон баталгаажуулсан гэдэг үгээр авахаар миний түрүүний хэлээд байгаа санал бол Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь уг эхийг Монгол Улсын Ерөнхийлөгч нотлон баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно гэхээр нөгөө нэг ёсондоо ёсчилсон өдрөөс эхлээд хүчин төгөлдөр болно гэсэн агуулгаар нь хийчихвэл.

Зүгээр ЗГ-ын саналаар ЗГ-ын оруулсан томъёоллоор явахаар ийм болчихоод байгаа юм л даа. Тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж дагаж мөрдөх харьцааг зохицуулах. Тэгэхээр хүчин төгөлдөр болох агуулга нь нөгөө Төрийн мэдээлэлд.

Х.Нямбаатар: Харин тэгээд энийгээ хууль дээр заачхаад байгаа юмыг хэдүүлээ дахин, дахин. Лувсанжав дарга та энэ дээр нэг зөвлөгөө өгчих. Энэ чинь хууль.../минут дуусав/

Г.Занданшатар: Лувсанжав дарга хэлчих. Тэгэхээр энэ Төрийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

мэдээлэл эмхэтгэлд хэвлэгдэх, албан ёсны эхэнд тооцох. Нотлон баталгаажуулсан гэдэг үг Ерөнхийлөгч нотлон баталгаажуулснаар л ёсчлогдож байгаа гэж үзээд хүчин төгөлдөр болно л гэсэн заалтаар хийчихсэн юм байна лээ өмнө нь бол 1 дүгээр зүйл. Ингээд явчихвал илүү тодорхой болчихно л гээд байгаа юм.

Энэ юугаар явахаар чинь байна шүү дээ төслийнхөөр явахаар чинь дагаж мөрдөнө гэсэн заалт болчихоод байгаа байхгүй юу. Дагаж мөрдөнө гэдэг маань Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулаад, шууд дагаж мөрдөх харилцаа биш болчихоод байна шүү дээ. 152-ыг тэр өдрөө дагаж мөрдөхгүй шүү дээ. 126-гаа ч байна уу. Дагаж мөрдөнө гэдэг үг чинь өөрөө зөрчилтэй болчихоод байна. Ганбат, Баасандорж 2 та 2 дагаж мөрдөнө гэдэг үг биш хүчин төгөлдөр болно гэдгээрээ явахгүй бол бид нар дагаж мөрдөх болчихоод байна шүү дээ. 126 гишүүн тэр өдрөөс чинь. Лувсанжав гуай хэлчих.

Н.Энхболд: Энэ нэг ийм юм байгаа юм.

Г.Занданшатар: Лувсанжав гуай хэлчих.

Н.Энхболд: Лувсанжав дарга аа, түр хүлээж байгаарай. Бид нар болохоор ажлын хэсэг дээр батлагдсанд тооцох, хүчин төгөлдөрт тооцогдох хоёрыг өөр ойлголт гэж хараад байгаа байхгүй юу, 1 дүгээрт.

2 дугаарт энэ хууль маань бол энэ хуулийг дагаж мөрдөнө гэж байгаа болохоос нөгөө нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх тухай юм энэ дээр бас байхгүй байгаа байхгүй юу. Энэ хуулиа дагаж мөрдөнө энэ хуулийг. Нэмэлт, өөрчлөлтийн тухай юм ороогүй. Батлагдсанд тооцно, тэгээд хүчин төгөлдөр болох уу гэдэг нь бол энэ Үндсэн хуулийн юу чинь бас арай жоохон нэмэлт процедуртай болоод байна л гэж бид нар харсан байхгүй юу. Тийм. Тийм, тийм. Маргаан гарах болов уу л гэж бид нар

үзээд байгаа юм, тийм. Лувсанжав зөвлөх нэг тайлбар хэлчих дээ. Энэ ажлын хэсэгт, дэд хэсэгт ажилласан юм.

Н.Лувсанжав: Энэ зүгээр найруулгыг зөвтгөхийн зэрэгцээ бас энэ дээр ажлын хэсэгт зайлиггүй анхааралд нь хандуулах ёстой хэд хэдэн асуудлууд байсан учраас бид бас энийг боловсруулсан л даа. Ер нь бол 1 дүгээрт жишигээ харахад бол 92 оны Үндсэн хууль болоод түүнээс хойш оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд бол нэмэлт, өөрчлөлт дээрээ өөрөө хэдийнээс хүчин төгөлдөр дагаж мөрдөх вэ гэдэг заалтууд нь явж ирсэн. Тийм, 19 оных ч бий, 92 оных ч бий. Хэдий хүчин төгөлдөр дагаж мөрдөнө гэсэн боловч жишээ нь одоо 92 оных бол Хавсралт хуулиар дагаж мөрдөхөд бүрнээ шилжих тухай хавсралт хууль гарч, тэр хоорондох шилжих харилцаанууд нь ямар хугацаанд, ямар зарчмаар шилжих юм бэ гэдэг тэр журмыг тогтоож өгсөн байгаа. 19 оных бол шууд одоо хүчин төгөлдөр болох, дагаж мөрдөх хугацаагаа бол 19 оны юу 20 оны 5 сарын 25 гээд тавьсан шүү дээ. Тийм, тодорхой хугацаатай байсан.

Үндсэн хуульд бол хууль батлагдаад хэвлэнэ хуульдаа өөрөө өөрөөр заагаагүй бол хэвлэн нийтэлсэн өдрөөс хойш 10 хоногийн дараа гэж байгаа юм. Гэхдээ энд бас эрх зүйн хувьд бас маргаан гарах вий гэж болгоомжилж байгаа. Энэ юу вэ гэвэл энэ Үндсэн хуулийн энэ заалт чинь хуульд хамаарах юм. Үндсэн хууль болоод түүнд оруулсан өөрчлөлтөд энэ чинь хамаарахгүй гэдэг маргаан гарч болно.

Дараагийн асуудал бол нэгэнт өөрчлөлт оруулсан бол энэ Үндсэн хуулийн дагуу дагаж мөрдөхөд шилжих үйл ажиллагаа эхлэх ёстой. Тэгэхээр энэ хүчин төгөлдөр болж байж тэр зарчмаар Сонгуулийн хуулиа ч одоо батлах ёстой, Их Хурлын болоод Их Хурлын дэг бусад хуулиудаа энд нийцүүлж батлах ёстой болно. Энэ ажиллагаа бол 24 оны ээлжит сонгуулиас хийгдэж дууссан байх ёстой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Өөрөөр хэлбэл 24 оны ээлжит сонгуулийн дүнгээр Их Хурал байгуулагдахад бол үйл ажиллагаа явуулах бүх эрх зүйн орчин нь бүрэн бүрдчихсэн байх ёстой л доо.

Тийм учраас 1 дүгээрт, энд үндсэн өөрчлөлт дээрээ хүчинтэй болох хугацаа тодорхойгүй байгаа учраас ямар хугацаанд энэ одоо Үндсэн хууль чинь мөрдөгдөөд явах юм бэ? Өөрөөр хэлбэл энэ зарчмыг юу Их Хурал юу үндэслэж энэ хуулиудаа өөрчлөх юм бэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм.

Нөгөө талаар энэ Дагаж мөрдөх журмын тухай Засгийн газраас оруулсан хуулийн 1 дүгээр заалт бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн 1 дүгээр зүйл одоогийн энэ Их Хуралд хамаарахгүй гэж байгаа юм. Хууль зүйн утгаар нь авч үзвэл энэ өөрчлөлтийг одоогийн Их Хурал мөрдөхгүй ч байж болно гэсэн агуулга гарч ирж байгаа байхгүй юу цаана нь. Харин ч одоо сонгуулийг татах, нааш нь татах, цааш нь татах ийм ч юм хийхийг үгүйсгэх байх, үгүйсгэхгүй, 1 дүгээрт.

2 дугаарт, нөгөө Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөсөө өөр ч асуудал ярьж болно гэсэн ийм агуулга гарч ирж байгаа юм. Уг нь бол би, бид бол ингэж ойлгож байгаа. Энэ бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлт гарснаас хойш дараагийн Их Хурал ээлжит Их Хурал бүрдэх хүртэл энэ Их Хурлаа хөндөхгүй юм байх ёстой эрх зүйн хувьд гэдэг асуудал. Өөрөөр хэлбэл энэ Их Хурлын бүрэн эрх хэвээр хадгалагдах ёстой гэдэг санаагаар одоо хийж байгаа гэж ингэж бодож байгаа. Энэ хэвээр хадгалагдана гэдэг чинь энэ хооронд.../минут дуусав/

Н.Энхболд: Занданишатар дарга, тэгээд Сүхбаатар дарга хэлээрэй.

Г.Занданишатар: Тийм. Энэ 1 дүгээрт 3 хугацаа Үндсэн хуульд байгаа гэдгийг бид ойлгочихмоор байгаа юм. Батлагдсанд тооцох өдөр, баталсан өдөр. 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 11 дүгээр сарын 19-ний өдөр

баталсан. 12 дугаар сарын 25-нд билүү, 26-нд Ерөнхийлөгч нотлон баталгаажуулаад хүчин төгөлдөр болсон. Түүн дээрээ Дагаж мөрдөх журмын тухай хууль дээрээ 20 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гээд заачихсан. Дагаж мөрдөх хугацаа нь 20 оны 5 дугаар сарын 25-наас дагаж мөрдөнө гээд.

Тэгэхээр энэ 3 хугацаагаа ялгахгүй бол хүчин төгөлдөр болох хугацаа, 92 оны Үндсэн хууль ч гэсэн 92 оны 01 дүгээр сарын 13-ны 11 цаг 30 минутад батлагдсан боловч Үндсэн хуулийнхаа далдугаар зүйлийн 2-т Монгол Улсын Үндсэн хуулийг 92 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 12 цагаас буюу усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гээд ингээд дагаж мөрдөх хугацаагаа өөрөөр тогтоочихсон.

Тэгээд дагаж мөрдөх хугацаа Баасандорж оо, дагаж мөрдөх хугацаа нэг тусдаа, хүчин төгөлдөр болох хугацаа нэг тусдаа. Тэгээд хүчин төгөлдөр болсон хуульдаа нийцүүлж бид Сонгуулийн хуулиа баталж байж дагаж мөрдөнө шүү дээ. Тийм. Ийм 3 хугацаа байгаа гэдгээ ойлгохгүй бол дагаж мөрдөнө гээд шууд зааж болохгүй, хүчин төгөлдөр болно гэдгээ зааж байгаа байхгүй юу. Нотлон баталгаажуулснаар буюу Ерөнхийлөгч ёсчилсноор хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болонгуут нь бид тэр хүчин төгөлдөр хуульд нийцүүлж Сонгуулийн хуулиа өөрчилнө. Тэгээд тэр Сонгуулийн хуулиа өөрчлөөд, тэр 24 оны 06 дугаар сарын 01-нээс ч байдаг юм уу дагаж мөрдөнө гэж ингэж заавал зөрчилгүй болох гээд байна.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн. Сүхбаатар гишүүн, дараа нь Нямбаатар.

Ж.Сүхбаатар: Би зүгээр ингээд л улсуудыг ингээд харахаар үгүй ээ, одоо манай Нямбаатар сайд бас сандраад л

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ингээд л юм хэлээд байх шиг байна. Ингээд л сая Лувсанжав гуай ч хэлж байна ингээд л. Энэ ажлын хэсгийн оруулж ирж байгаа зарчим чинь ер нь бол зөв байхгүй юу. Энэ чинь шинээр юм бодож бичээгүй байна шүү дээ. Өмнөх яг практикаараа хийгээд л. Хүчин төгөлдөр болно гэдэг чинь бол хуулийн үйлчлэх хүчин чадал, үйлчлэлийн хугацааг хэлж байгаа юм. Үйлчилж эхлэх хугацаа. Энэ шилжилтийн үеийн журам чинь өөрөө нэг төвөгтэй хийгддэг байхгүй юу. Хүчин төгөлдөр үйлчилчихсэн, үйлчилж байгаа мөртлөө хуучин хуулиа, одоо байгаа хуулиа үйлчлүүлэхийг шаарддаг.

Тэгээд нөгөө төгс гүйцэтгэлтэй дараагийн хууль залгаж авах хүртэл ингэж зэрэгцэж явдаг байхгүй юу. Угаасаа л тэгж явдаг. Одоо жишээлбэл, бид нар 126 гэж баталчхаад үүнийг баталсан уу, баталлаа гэж бодоход бид нар ингээд кнопоод баталлаа гэж бодоход хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа тусдаа, хүчин төгөлдөр үйлчлээд ирэнгүүт техникийн хувьд ямар зөрчил үүсдэг вэ гэхээр тухайн хуулийг үгүйсгэдэг. Гэтэл үгүйсгэсэн ч гэсэн дараагийн харилцаанд дахиад өөр үед үйлчлэх гэж байгаа учраас байгаа үеийн тэр хуулийг чинь үйлчлэлтэй нь хэвээр хадгалж үлдэх ёстой.

Тэгэхээр тэр дагаж мөрдөнө, бүрэн эрхийн хэвээр хадгална, хүчин төгөлдөр болно гээд энэ ажлын хэсэг оруулж ирчихсэн байна шүү дээ. Энэ чинь агуулгаараа бол бид нарын болзошгүй бүх юмыг үгүйсгээд ингээд янзлаад өгчихсөн байгаа байхгүй юу. Тэр хүчин төгөлдөр болно, батална гээд нэг маргаад байх юм байхгүй шүү дээ. Тэртээ тэргүй энэ дотор чинь одоо бид нар 126 гэхээр чинь 76 гишүүнтэйгээ явж байж, 24 оны парламентын одоо сонгууль дуустал ингээд явна шүү дээ. Тэгэхээр энэ Их Хурлын чинь хууль хүчинтэй явж байна. Гэтэл яг энэ батлагдахаар энэ Үндсэн хууль чинь хүчин төгөлдөр болчихсон үйлчлэлд орчихсон байгаа мөртөө тэр хуулийг чинь угаасаа үгүйсгэчихнэ.

Тэгэхээр тэрийг чинь үгүйсгэчихсэн юмыг чинь өөрчлөхийн тулд Үндсэн хуулийн хүчинтэй ийм өөрчлөлтийг хажууд нь давхар хийж өгч байгаа биш, шилжих журам гэж байгаа юм. Шилжиж байгаа байхгүй юу. Шинэ, хуучин 2 чинь зэрэг шилжиж чаддаггүй байхгүй юу. Нэг хэсэг зөрчилтэй явагдаж байгаад шилжиж байгаа учраас энэ дотор одоо ингээд дагаж мөрдөнө, хэвээр хадгална энэ буруу, зөрүү гээд яриад байгаа энэ чинь тэрийг л хооронд нь нийцүүлээд л нөгөө ацаг шүдний зөрүү гэдэг шиг хооронд нь нийцүүлээд л явчхаж байгаа байхгүй юу. Тийм.

Үгүй ээ, үгүй энэ харин бид нарын яриад байгаа юм чинь болгоомжлолоос байна шүү дээ. Их Хурал хугацаанаасаа өмнө тарахгүй юм байна, бүрэн эрх нь хэвээр байх юм байна. Тэгээд сонгууль дуустал тэр дараагийн Их Хурал гарч иртэл одоо байгаа хуулиуд нь хүчин төгөлдөр үйлчлэх юм байна. Тэгсэн хэр нь Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь хүчин төгөлдөр үйлчлэлээ тодорхой, одоо бид нарыг баталсны дараа тодорхой цаг хугацаанд үйлчлээд явах юм байна гээд энэ болгоныг чинь яг давхар давхар ингээд нөгөө талаас нь зөрүүлээд хийчихсэн байгаа байхгүй юу. Үүнийг чинь одоо үгүйсгээд явчихвал янз бүрийн асуудлууд гарна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь одоо саяын тэр Лууяа даргын хэлээд байгаа чинь энэ Хууль зүйн сайд байсан хүн. 92 онд Үндсэн хууль яасан. Сая бид 19 онд нэг асуудал үүссэн шүү дээ. 5 сарын 25-наас хүчин төгөлдөр үйлчилчихсэн чинь ЗГ одоо солигдох ёстой. 4 хүнтэй байх ёстой гээд л ингээд л ярьж байгаа юм. Гэтэл тэр чинь шилжилтийн юмаараа бид нар уг нь юм хийчихсэн гэсэн чинь манай зарим хуульчид чинь мушигж гуйвуулаад л тайлбарлаж байгаа юм. Түүн шиг яг энэ дотор бол ингээд харахад би бол бүрэн эрхээ хэвээрээ хадгална гэдэг чинь энэ Их Хурал бол ингээд энэ Үндсэн хууль батлагдсан ч гэсэн энэ 20 оны сонгууль дуусах юм байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгээд бас энэ Их Хурлын тухай хууль 76-гаар явж ирсэн, Сонгуулийн хууль эд нар дараачийн сонгуулийг хүртэл үйлчлэх юм байна. Гэхдээ 24 оны сонгуулийн хууль нь шинээр явагдах юм байна. Тэр хооронд Их Хурлын хууль бас өөрчлөгдчихсөн байгаад тэр өөрчлөгдсөн хууль нь 24 оны тэр сонгуулийн дараа шууд үйлчлэх юм байна гээд. Бид нар чинь нэлээн хэдэн хуулийг өөрчилнө шүү дээ, одоо энэ. Тэгэхээр яг энэ болгон тэнд тусаж уу гэхээр энэ тусчихсан л харагдаад байгаа юм л даа. Үүнийг чинь одоо юу нь бид нарт саад болчих гээд, юу нь хориг болчих гээд байгаа юм. Харин тэрийг чинь бид нарын болгоомжлоод Засгийн газрын ч гэдэг юм уу, Их Хурлын болгоомжлоод байгаа юмнууд чинь энд орчихсон л байгаа байхгүй юу, Тийм.

Н.Энхболд: Нямбаатар аа, микрофоноо, микрофоноо. Нямбаатар гишүүний микрофоныг өгчих.

Х.Нямбаатар: Үгүй ээ, үгүй бид нар байна шүү дээ тийм ээ. Сүхбаатар гишүүн маш их хууль зүйн техник ярьдаг л даа. Би яг хууль зүйн техник талаасаа хэлээд байгаа юм. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд биччихсэн байгаа үгийг бид нар чирч авчраад дахиад шилжих журмын хуульд бичнэ гэдэг чинь Зандан даргын хэлээд байгаа юу чинь энэ журмын хуульд байгаа шүү дээ.

18.3 дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн нотлон баталгаажуулсан уг эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд байршуулж, төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эхэд тооцно гэж байгаа. Тийм, тийм. Би юу гэж хэлэх гээд байна вэ гэвэл энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд байгаа зүйлийг бид нар дахиж энэ шилжих журмын хуульд бичнэ гэдэг нь өөрөө хууль зүйн техникийн хувьд алдаа 1 дүгээрт.

2 дугаарт, би юу хэлэх гэж байна вэ гэвэл байна шүү дээ, бид шууд хүчээр, би энэ зүгээр дараа нь улс төрийн асуудал би сөрөг хүчнийг бүү сөхөж тавиасай гэж бодож байгаа юм. Энэ юу вэ гэхээр, бид нар ингээд биччихэж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Их Хуралд хамаарахгүй гээд Засгийн газрын төсөл бичиж байгаа байхгүй юу.

Тэгвэл ажлын хэсгээс ингээж байгаа юм. Та нар ер нь тэгж ярих юм бол 24 он хүртэл тарахгүй шүү гээд биччихэж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд байгаа Улсын Их Хурал өөрийнх нь тарах тэр эрхэд шууд энэ шилжих журмын хуулиараа халдаж байна. Энэ өөрөө хууль зүйн техникийн болоод Үндсэн хуулийн шинэ чанартай хууль тогтоомжуудын хооронд зөрчил үүсгэж байна. Тэгэхээр бид нар энэ байгаа юугаараа явах, одоо өргөн барьсан төслөөрөө явах нь хамгийн зохимжтой. Хууль зүйн техникийн хувьд гуравхан заалттай ингээд явчихъя л гэсэн ийм агуулгаар л би асуудал тавьж байгаа байхгүй юу.

Тэгээд дээр нь ажлын хэсгийн тэр оруулж ирж байгаа.

16.3 нь 16.8 хоёр чинь 2 өөр үг байхгүй юу. 16.3 нь Ерөнхийлөгч уг эхийг нотлоод тэр юундаа Үндсэн хуулийн эхийг өргөөндөө хадгалж байгаа хэлбэр.

16.8 нь болохоор ингээд нийтлэгдээд, нотлон баталгаажуулаад одоо нийтэлчихвэл ингээд албан ёсны эх болчихлоо шүү, хүчин төгөлдөр болчихлоо шүү гэдэг ийм зохицуулалт байгаа учраас Засгийн газар бодож байж ийм 3 заалт оруулж ирсэн байхгүй юу.

Гэтэл үүнийг ингээд задлаад 1 дүгээрт, чи тарж болохгүй.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2 дугаарт, энэ нотлон баталгаажуулалт, тэр өргөөндөө гарын үсэг зурсан өдрийг шууд баталсан одоо хүчин төгөлдөр хугацаа болгож тавиад, Үндсэн хуульд оруулах тэр нөгөө Үндсэн хууль өөрчлөгдсөнтэй холбоотой харилцаануудыг бид нар өөрсдөө хуваарь гаргаад Их Хурал бүрэн эрхийнхээ хугацаанд баталчихъя гэнгүүт үгүй ээ, та нар ирэх оны 6 сарын 1-ний дотор бүгдийг нь баталж дуусга аа. Би энд бүр хамгийн том ноцтой нэг алдаа байгаа Энхболд дарга аа.

Тэр юу вэ гэхээр шинээр байгуулагдах Их Хурал энэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй уялдуулж өөрөө дэгээ батлах ёстой байхгүй юу, өөрөө дэгээ батлах ёстой. Гэтэл та энэ ажлын хэсгийн юун дээр юу гэж баталж байна гэхээр чи шинэ Их Хурал батлагдахаас, байгуулагдахаас өмнө энэ өөрчлөлттэй холбоотой 126 гишүүнтэй дэгийг энэ хуучин Их Хурал батал гэж үүрэгжүүлж байгаа байхгүй юу. Энэ өөрөө болохгүй байхгүй юу. Шинэ Их Хурал өөрөө гарч ирээд энэ Үндсэн хуулийнхаа өөрчлөлттэй уялдуулж өөрөө өөрийнхөө дэгийг 126-даа таацуулж, нийцүүлж гишүүд нь өөрсдөө баталдаг.

Бид нар нэг зарчим руу яваад байгаа шүү дээ, Энхболд дарга аа. Дэгийн тухай хуулийг өөр субъектүүд хэзээ ч хэлэлцэж болохгүй. Дэгийн тухай хуулийг зөвхөн Их Хурлын гишүүдийн өргөн барьснаар нь баталдаг, Их Хурал өөрөө өөрийнхөө үйл ажиллагаа явуулах тэр дэг процедураа баталъя гэж байгаа юм. Тэгэхээр энэ та хэдийн энэ зарчмын зөрөөтэй саналаар бол биднийг ирээдүйд бий болох ирэх оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдах Их Хурлын дэгийн хуулийг шууд батал гээд тулгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ болохгүй байгаа юм. Сүхээ сайд аа. Үүнийг та хэд нэг харцгаа.

Би бол Засгийн газрын энэ юугаараа явчихвал ... /минут дуусав/

Н.Энхболд: Би буруу тайлбарт нэг залруулга өгөөдөхье. Дэгийн тухай хуулийг энэ дараагийн дэгийн хуулийг энэ Их Хурал батлахгүй ээ. Энэ дээр тэгж бичсэн юм байхгүй. Та зүгээр ургуулж бодоод бусад хууль тогтоомж, ганц дэгийн тухай, ганц дэгийн тухай хууль ч биш Их Хурлын тухай хууль байна, тийм ээ. Дэгийн тухай хууль гэж наана чинь байхгүй. Тийм ээ, тэгэхдээ энэ дотор дэгийн тухай хууль гэж байхгүй шүү. Бусад өөр өөр хуулиуд бас, өөр хуулиуд байгаа 1 дүгээрт. Өөр хуулиуд байгаа. Зүгээр ингээд байгаа юм. Би энэ цаана яагаад ийм асуудал өрнөөд байгааг одоо мэдэж байгаа. Яг энэ заалт дээр.

Тэгэхээр зүгээр нэг вариант бол юу гэж байж болох юм гэхээр жишээ нь Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь 15.8-ын дагуу гээд ийм юм тохиолдолд, батлагдсанд тооцогдож, тэгээд үлдсэн зохицуулалтууд нь хүчин төгөлдөр болох зохицуулалт нь өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу хүчин төгөлдөр болно гээд л заачихсан байхад энэ ерөөсөө буруудах юм байхгүй байгаа, уг нь. Өөрөөр хэлбэл батлагдсанд тооцохыг зориуд дурдъя, тэгвэл. Ямар тохиолдолд, хэзээ, хэдний өдөр батлагдана, тэр үед нь хуулиараа батлагдсанд тооцогдож байгаа. Гэхдээ хүчин төгөлдөр болох хугацааг нь бас энэ дээрээ ерөнхий зохицуулалтыг нь бичээд, тэр журмын дагуу хүчин төгөлдөр болсон тэр зохицуулалтын дагуу хүчин төгөлдөр болно гээд л заачихсан байхад наад маргаан чинь, болгоомжлоод байгаа юмнууд бол гарахгүй л гэж бодож байна.

Амараа гишүүн. Амарсайхан сайд үгээ хэлээдэхье. Тэгээд

С.Амарсайхан: Нэлээн сонсож, ажиглаж суулаа. Энэ одоо их айхтар будилаад маргаад байх асуудал биш л дээ. Маш тодорхой 3 үе шат бүхий процесс л байгаа шүү дээ. Их Хурал дөрөвний гурваараа батална. Батлахгүй бол Ерөнхийлөгч ёслон нотлохгүй, ёслон нотлохгүй бол хүчин төгөлдөр одоо

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дагаж мөрдөх тухай асуудал байхгүй ийм л асуудал.

Гэтэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай асуудал, ёсчлон нотлох тухай асуудал 2-уулаа дагаж мөрдөх журмын тухай хууль дээр маш тодорхой заачихсан байгаа. Маш тодорхой заачихсан байгаа. Одоо бид нар энэ дээр юу гэхээр хэрвээ Засгийн газраас оруулж ирсэн санал эргэлзээтэй, ойлгомжгүй байна аа гэвэл энэ дээр ганцхан л асуудал ярих ёстой. Бид хэзээнээс эхэлж дагаж мөрдөх юм бэ гээд.

Харин түрүүн ярьдаг шиг 20 оны Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бий болсон Их Хурлын бүрэн эрхэд хамаарахгүй гэдгээ тодорхой болгоод л заагаад өгчих. Буцаад нөгөө талд нь 24 он хүртэл, 24 оны 6 сарын 15 хүртэл гээд бас ийм 2 салаа утгатай ийм агуулга бүхий заалт оруулж бол болмооргүй байгаа. Эсвэл 24 оны 6 сарын хэднээс гэдэг юм, маш тодорхой үйлчилнэ ээ л гэдэг үйлчлэлийнхээ хугацааг энэ дээр тодорхой болгочихъё. Тэгээд санал хураалгачихмаар байна.

Харин тэр Ерөнхийлөгч ёсчлон нотлох тухай асуудал дээр хугацаа зааж болохгүй. Ерөнхийлөгч хориг тавих уу, ёсчлон батлах уу гэдэг асуудал бол Их Хурал баталчихсаны дараа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал. Энэ дээр бид 6 сарын тэдний дотор эс үгүй бол Их Хурал нэмэлт, өөрчлөлтийг баталсны дараа Ерөнхийлөгч тэд хоногийн дотор ёсчлон нотолно гэдэг ийм хугацаа зааж болохгүй.

Н.Энхболд: Тэр чинь угаасаа хуулийн хугацаатай л даа.

С.Амарсайхан: Тийм, угаасаа хуулийн хугацаа нь маш тодорхой байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар дахиж тэр заалтаар, зүйлээр оролдох ямар ч шаардлагагүй байгаа байхгүй юу. Тийм учраас одоо зүгээр бид нар үүнийг

хуралдаа хэрхэн яаж үйлчлэх юм, үйлчлэхгүй юм гэдгээ тодорхой томъёолоод л саналаа хураагаад л явчихмаар байна. Тэгээд энэ чинь бүтэн 2 цаг энэ асуудлаар бид маргалаа шүү дээ.

Н.Энхболд: Энд нэг ийм л ялгаа байгаа юм л даа, Амараа дарга аа. Дараа нь би танд өгнө.

Ердийн хууль баталгаажсаад хүчин төгөлдөр болох нэг өөр зохицуулалттай. Тийм ээ. Үндсэн хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт болохоор батлагдсанд тооцогдох, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх 2 нь өөр зохицуулалттай байгаа байхгүй юу. Энэ зөрөө дээрээс л асуудал үүсээд байгаа юм.

Хууль санаачлагчаас нэг санал сонсчихъё. 2 номерын микрофон.

Д.Амарбаясгалан: Би нэг 2 зүйл хэлээд, 1 асуулт асуучихъя гэж бодож байна.

Асуултаа эхлээд асуучихъя. Энэ яагаад өмнөх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдэд орсон өөрчлөлт нь хэрэгжих хугацаагаа өөр дээрээ заагаад явж байсан бэ. Яагаад энэ удаагийн өөрчлөлтийг заавал дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулах гээд байна вэ гэж ингэж асуумаар байгаа юм. Тэр Лувсанжав гуайн түрүүн хэлсэн тайлбарыг сонсоод тэгж бодлоо. 19 онд хийсэн нэмэлт, өөрчлөлт өөр дээрээ хэрэгжих хугацаагаа заагаад явсан. Одоо харин энэ дээр бол зааж болохгүй байна гэхэж байгаа юм. Тэгэхээр ингээд одоо өнөөдрийнхөө нөхцөлд тааруулсан байдлаар ийм тайлбар хийж явмааргүй байна.

Өмнөх 3 удаагийн орсон нэмэлт, өөрчлөлт өөр дээрээ хугацаагаа заагаад л явж болсон. Яг түүнтэй адилхан энэ дээр хэрэгжих хугацааг өөр дээр нь зааж явах нь зарчмын хувьд дабл стандартгүй байх зарчмаараа асуудал нь зөв юм аа гэж бид нар итгэж үнэмшиж байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2 дахь зүйл бол, Засгийн газраас өргөн барьсан дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл дээрээ энэхүү өөрчлөлт нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй ээ гээд тодорхой заагаад ороод ирчихсэн байхад одоо сонгууль ээлжит бус гэдэг ийм улс төрийн шинж чанартай ойлголтууд өгч байгаа нь бас ямар учиртайгаар энэ асуудлыг ингэж гуйвуулаад байна гэж ингэж харж байна. Ээлжит бус сонгууль явуулах тухай энэ өргөн барьсан төсөлд огт тусгаадаагүй. Харин ч 20 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй ээ гээд маш тодорхой 1 дүгээр зүйл дээр нь заачихсан байхад үүнийг зориудаар өөрчилж орж ирж байгаа нь ер нь ямар учир байна гэж бас гайхаж байна.

Тэгэхээр үүнийг ер нь зүгээр зарчмын хувьд 1 дүгээрт, өмнө нь батлагдаж байсан Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтүүдийн нэгэн адил хэрэгжих хугацааг өөр дээр нь хийж өгөх.

2 дугаарт, тэр яг хуулийн хүмүүс, мэргэжлийн хүмүүсийн үг хэллэг яваад байх шиг байна, 2 ойлголт яваад болохгүй. Нэг бол үүнийг чинь нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурал эцэслэн батлаад, ёсчлох ажлыг Ерөнхийлөгч хийх ёстой. Тэгэхээр зарим хүмүүсийнх нь хэлж байгаа тайлбараар болохоор Ерөнхийлөгч гарын үсэг зурснаар энэ нь албан ёсоор батлагдаж байгаа мэт ойлголт өгөх гэж яриад байна шүү дээ. Тэгэхээр үүнийг чинь Улсын Их Хурал батлахгүй Ерөнхийлөгч баталж байгаа юм шиг тийм ойлголт руу явах гэж ажиглагдаад байна. Тэгэхээр энэ 2 зүйлийнхээ ялгаа, заагийг сайн гаргаж, тайлбарлаж ойлгуулахгүй бол яг мэргэжлийн хүмүүсийн мэтгэлцээн ч бас бүрэн ойлголт өгөхгүй болчих гээд байна шүү.

Н.Энхболд: 1 дүгээрт, хууль санаачлагч асуух дэг байхгүй, тийм, Амарбаясгалан дарга аа.

Тэгэхдээ бас ноцтой асуудал тавьж байгаа учраас би зүгээр нэг тайлбар хэлчихье. Үндсэн хуульд нэмэлт оруулах журмын тухай хуулийн 13.3 дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал яривал тэр үед нам, эвслийн бүлгүүд санал, дүгнэлт гаргаж болно. Байнгын хороо, гишүүн төсөлд тусгаадаагүй шинэ хэсэг, заалтын томъёоллын санал, дүгнэлт гаргаж болохгүй гээд заачихсан юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн өөрчлөлт дээр маань ерөөсөө 1 л заалттай. Тэр нь 76-г мажоритарар, 76-г пропорционалиар гэсэн, өөрөөр хэлбэл сая таны асуусан нөгөө тэр анхнаасаа оруулж ирсэн Үндсэн хуулийнхаа юун дотор дагаж мөрдөх хугацаа байхгүй байсан учраас Их Хурлын гишүүд тэрийг нь нэмж оруулах бололцоо байхгүй байгаа юм. Ийм байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнээс яаж гарах вэ гээд л ийм зохицуулалтуудыг хийж байгаа юм. Ер нь бол тэр жишээ нь 24 оныг энэ тэр гээд заачихсан юмнууд бол хэвээр хадгална ч гэдэг юм уу хамаарахгүй энэ 2 цаагуураа яг л адилхан утгатай ийм заалт байгаа юм, байж байгаа юм. Энэ дээр бол нэг өөр болгоод янз бүрийн санаа орсон юм ажлын хэсгийн зүгээс байхгүй. Яагаад Үндсэн хуулийнхаа юман дээр нь оруулж хамт оруулаад ирээгүй юм бэ гэдэг дээр бол одоо Засгийн газраас оруулж ирээгүй болохоор гишүүд нэмж болохгүй ийм л зохицуулалттай.

Тэгээд Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн зохицуулалт нь өөрөө ердийн хуулийнхаас арай өөр болохоор л ийм л асуудлууд үүсээд байгаа юм л даа. Дахиад хэлэхэд, бид энэ дээр Засгийн газрын оруулж ирснээс л илүү ямар нэг нь санаа оруулаагүй, эс үгүй бол оруулж ирснийг нь хасаагүй. Зүгээр дараа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцэх, батлах, хүчинтэй болох зохицуулалт нь арай өөр байдаг болохоор түүнтэй холбогдсон янз бүрийн маргаан

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гарах вий дээ л гэж бодож, ийм тодруулсан маягаар л оруулсан юм. Нэгийг нь дотор нь 2 хуваасан, хамаарахгүй гэдгийг нь энэ бол одоо энэ Их Хуралд хамаагүй шүү гэдгийг нь хэлсэн. Өөрөөр хэлбэл, энэ удаа, ингээд Үндсэн хууль энэ 6 сард батлагдчихлаа гэж бодоход Үндсэн хууль 126 болно гэсэн юм чинь энэ хурлыг тараагаад 126 гишүүнтэй болох тухай асуудал яригдаж байхгүй шүү гэдгийг тухайлбал зааж оруулж өгсөн. Ийм л заалтууд байгаа юм л даа.

Одоо дэгээрээ бол ингээд Байнгын хороон дээр энэ орж ирсэн саналуудыг хураагаад, дэмжихгүй гэвэл Засгийн газраас орж ирсэн санал хэвээрээ үлдээд л ингээд л явах ёстой, тийм.

Тэгэхээр хоорондоо уялдаа холбоогүй тийм саналууд үлдчих вий дээ л гэж бодоод байна л даа би, тийм.

Зандан дарга, Их Хурлын дарга.

Г.Занданшатар: Тэгээд энэ хууль санаачлагч өргөн барихдаа нэг ийм өдөр 2 хийчихээд байгаа юм л даа, энэ.

3 дугаар зүйл дээр Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдөр гэж нэг өдөр байх гээд байхгүй юу. Тэр өдрөөс эхлээд дагаж мөрдөнө гээд биччихээд байгаа байхгүй юу. Хүчин төгөлдөр болох болсон өдөр гэж нэг өдөр байх гээд байна шүү дээ. Тэгээд хүчин төгөлдөр болох процесс нь бол батлах өдрөөс тусдаа байх гээд байна шүү дээ, тийм ээ.

18.4-д зааснаар бол яах вэ, төрийн мэдээлэлд нийтлэгдээд албан ёсны. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн тэр албан ёсны эхийг нотлох гэдэг процесс, хадгалах энэ бүх процесс чинь ёсчлох гэдэг агуулгатай байна гэж үзээд, батлагдсанд тооцчихлоо. Нийтэд зарлан мэдээлчихнэ, Улсын Их Хурал. Процессоо дуусгачихсан. Улсын Их Хурал хуулиа баталчихсан.

Одоо ч гэсэн хүчин төгөлдөр болох хуулийн заалтуудыг хэзээнээс эхлээд хүчин төгөлдөр болох вэ гэдгээ зааж байгаа юм. Энэ бол ингээд төрийн мэдээлэл сэтгүүлд нийтэлсэн гээд яг тэр ердийн журмаар явж болохгүй юм байна, Үндсэн хууль учраас гэж байна, тийм ээ. Тэгэнгүүт энэ чинь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэдэг чинь өөрөө зөрчил үүсгэхээд байгаа байхгүй юу. 2 дугаар зүйлтэйгээ ч гэсэн дагаж зөрчилдөөд байна, дагаж.

Тэгэхээр хүчин төгөлдөр болно гэдгийг нь 16.3-д заасан тэр өдрөөр хүчин төгөлдөр болгоё гэж нэг тусад нь зааж байна, тийм үү. Хүчин төгөлдөр болчихлоо. Дагаж мөрдөх хугацаа бол ганцхан заалт үндсэндээ 24 оноос дагаж мөрдөнө гэсэн агуулгатай нэг заалт ороод байна. Өөрөөр хэлбэл энэ одоогийн Их Хуралд үйлчлэхгүй энэ тэр гэж. Тэгсэн мөртөө хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө гэх юм бол энэ ойлгомжгүй байдал үүсгэж болзошгүй байхгүй юу. Тийм учраас хүчин төгөлдөр болно гэдгээ тэр ёсчлон баталгаажуулснаар гэнэ үү, нотлон баталгаажуулсан, журмын тухай хуулийн үг нь нотлон баталгаажуулсан гэж байгаа учраас нотлон баталгаажуулсан өдөр буюу тэрийг нэг бол шууд үгээр нь бичиж болж байна. Нэг бол 16.3-ваа эшлэхээр Нямбаатар сайд 16.3-ыг чинь хадгалахтай холбоотой харилцааг шууд өдөр болголоо гээд байгаа учраас дундуур нь тэр нотлон баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно гээд үгчилчихье гэж эшлэхгүйгээр сикл хийхгүйгээр үгчилчихье гэж яриад байна шүү дээ.

Тэгэхгүй бол нэг нөгөө ингээд 2 талаас нь өөр өөр талаар Ерөнхийлөгчид тэгэх гэж байна. Ерөнхийлөгч бол үндсэндээ манай Үндсэн хуулиар дээд танхимын үүрэг л гүйцэтгэж байгаа юм. Дээд танхим чинь хориг тавих болон нотлох ийм л статустай байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр нотлох процесс дуусахаар ёсчлогдсон гэж үзээд,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ёсчлохгүй бол бас энэ чинь асуудалтай, хүчин төгөлдөр болсон гэж үзэгдэхгүй яваад байх нь байна шүү дээ. Тийм учраас үүнийг аль нэг эрх мэдэл нь халдаж байгаа юм уу, өөрчилж байгаа асуудал биш. Хүчин төгөлдөр болсон гэдэг заалтыг нь нэг бол тэр нотлон баталгаажуулсан өдрөөс гэдгээр нь болчхож болж байна. Нэг бол 16.3-аас силк хийж.

16.3 гэхээр зөрчил үүсгэнэ гээд Нямбаатар сайд хадгалах, нотлон баталгаажуулах өдрийг тэр заалтыг эшлэх гээд байна гэхээр бас хууль зүйн техникийн хувьд алдаатай байж болзошгүй учраас тэгээд л явчихвал болчхож байгаа юм. Ердийн журмаар явчих юм бол бид нар байна шүү дээ, б сарын 20-ноос өмнө Сонгуулийн хуулиа баталж чадахгүй.

Н.Энхболд: Зандан дарга аа, би түрүүн хэлсэн. Нямбаатар сайд аа, та сонсож бай даа. Яах вэ, 1 дүгээр заалтаа бол ийм байдлаар өөрчилж болж байгаа юм. Сая ерөнхийдөө санаа нь бол Их Хурлын даргын хэлсэнтэй адилхан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг журмын тухай хуулийн 15.8-д заасны дагуу одоо тэдэн хувийн саналаар ингэвэл батлагдсанд тооцож гээд шууд батлагдсанд гэдэг үгээ орхичхоод, тооцож тэгээд журмын тухай хуулийн зохицуулалтын дагуу хүчин төгөлдөр болно гээд л оруулчихвал заавал хугацаа тавихгүй. Тэртээ тэргүй хууль дээр байгаа заалтууд нь орох байхгүй юу.

Заавал тэрийг нь бичих албагүй зүгээр.

Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгөөдөх дөө.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгээд энэ журмын тухай хууль дээр бас санал нэгтгэх, дахин ярилцах ийм шаардлага байгаа учраас 2 цагийн хугацаатай Монгол Ардын намын бүлэг нэг завсарлага

авч, ярилцах хэрэгтэй байгаа учраас 2 цагийн түр завсарлага хүсэж байна.

Н.Энхболд: Ардын намын бүлгийн зүгээс түр завсарлага авах хүсэлт гаргасан учраас 2 цаг, ажлын хэсэг бусад холбогдох хүмүүстэй ярих, санал солилцох бололцоо олгоё.

Түр завсарлая. 2 цагийн хугацаатай.

ЗАВСАРЛАГА

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ оройн мэнд хүргэе.

Түрүүн Ардын намын бүлгийн дарга түр завсарлага авсан. Тайлбараа хийгээд хурлаа үргэлжлүүлэе гэвэл асуудлаа хэлэлцээд үргэлжлүүлээд явъя. Тогтохсүрэн даргын микрофоныг өгөөрэй.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөх шилжих журмын тухай хууль дээр 3 цагийн завсарлага авсан. Тэгээд манай бүлгийн гишүүд, ажлын хэсгийн гишүүдтэйгээ нэг бүрчилж яриад, томъёоллуудаа цэгцлээд ингээд асуудлаа цэгцэлсэн. Тийм учраас бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссан тул хуралдааныг үргэлжлүүлэе гэдэг ийм саналтай байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Түрүүн бид нар асуудал дээрээ явж байгаад Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхны төслийн хэлэлцүүлгийн эхэн дээр зогссон. Албан тушаалтнуудаа танилцуулчихсан.

Зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлнэ.

Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулт байвал нэрсээ өгнө.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Түрүүн асуулт гараагүй, саналууд гарч байгаад зохицуулах журмаар болсон. Тэгээд ажлын хэсгээс тодорхой саналуудыг томъёолоод оруулж ирсэн байгаа. Ингээд хуулийн төсөлд дараах агуулга буюу 1 дүгээр зүйл нэмэх. Гишүүдэд тараагаад өгчихвөл сайн байна. Юу ч гэсэн сонсож байх уу, хэдүүлээ.

1 дүгээр зүйл. 23 оны тэд дүгээр сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.4-д заасны дагуу нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ ямар агуулгатай заалт вэ гэхээр батлаад, Ерөнхийлөгчид хүргээд, ёсчлоод, албажуулаад, тэгээд төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдээд хүчин төгөлдөр болох хугацаануудыг багтаасан агуулгатай ийм заалт байгаа.

Энэ дээр саналтай, асуулттай гишүүн байна уу. Алга байна. Тэгвэл 1 дүгээр зүйлд оруулж байгаа саяын агуулгатай томъёоллыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж 78.6 хувиар санал дэмжигдлээ.

Өөр 1 дүгээр зүйлтэй холбоотой байхгүй билүү.

1 дүгээр зүйлийн 2 дахь заалт байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2023 оны дугаар сарын тэдний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн 1 дүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын нийт гишүүний тоо Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд

хамаарахгүй гэсэн ийм заалт ажлын хэсгээс гаргасан.

Холбогдуулж асуух гишүүн байна уу. Алга байна.

Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гаргасан санал байна. Ирүүлсэн төслөөс асуулттай гишүүн алга байна.

Тэгвэл 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах санал ажлын хэсгээс гаргасан.

3 дугаар зүйл 2023 оны ... дугаар сарын тэдний өдөр болсон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу олныг төлөөлөх буюу мажоритар хувь тэнцүүлэн хуваарилах пропорциональ тогтолцоог хослуулан явуулах зохицуулалтад Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.

Асуулт байна уу. Алга байна. Дуусгасан байх. Анхааръя. Санал хураалт.

Бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг гэж байгаа юм, тэрэндээ. Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу гэж байхгүй дээ, хуваарийн дагуу гэж байгаа юм, Их Хурал. Хаана байна вэ. Өөрчлөлтийг үндэслэн. Өөрчлөлтийг үндэслэн. Найруулгаа дахиад харъя.

Хэлэлцэн шийдвэрлэнэ. Хүлээж байгаарай. Саяын редакцуудыг харгалзъя. Саналаа хураая.

Санал хураагаагүй. Санал хураалт.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71.4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 2 дугаар зүйл дуусчхаж байна уу, тийм ээ.

3 дугаар зүйл. 3 дахь санал.

Хуулийн төсөлд дараах агуулга бүхий 4 дүгээр заалтыг, 4 дүгээр зүйл нэмнэ. Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй. Санал гаргасан ажлын хэсэг.

Асуулт байна уу? Алга байна. Санал хураалт.

Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Би зүгээр сая Нямбаатар сайдаас бас тодруулж байсан юм. Энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт ороход дагаж мөрдөх шилжих журмын тухай хууль өөрөө Үндсэн хуулийн нэгэн адил үйлчилнэ гэдэг нь яг хууль зүйд нийцэж байна уу? Өөрөөр хэлбэл нөгөө Үндсэн хуульд Үндсэн хуулийн бус аргаар халдах, өөрчлөлт оруулах гэдэг зүйл рүү орох ийм эрсдэл, янз янзын шалтгаан дараа нь болохгүй. Яагаад гэх юм бол Үндсэн хууль өөрөө $\frac{3}{4}$ -аар батлагдаж байгаа.

Гэтэл энэ мөрдөхөд шилжих журмын тухай хууль бол өөрөө ердийн олонхоор батлагдаж байгаа. Тэгсэн мөртөө Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр байна гэдэг энэ заалт хэдийгээр шилжих процессыг зохицуулж байгаа ч гэсэн өөрөө Үндсэн хуулийн нэгэн адил үйлчлэх тийм хууль зүйн үндэслэл байж чадах уу, үгүй юү гэдгийг маш сайн тооцож, энэ зүйл, заалтыг оруулахгүй бол энэ эргээд өөрөө Үндсэн хуулиа гацаасан, Үндсэн хуулийн өөрчлөлтөө үгүйсгэсэн, Үндсэн хуулийн цэц дээр хүртэл асуудал яригдах, Үндсэн хуульд хууль Үндсэн хуулиас гадуур Үндсэн хуулийн байгууллагад халдсан ийм эрхэнд халдсан нөхцөл байдал үүсэх болзошгүй

зүйлүүдээ бас эргээж харсан уу гэдгийг тодруулъя гэж харж байгаа юм.

Н.Энхболд: Энэ талаар бас нэлээн сайн ярилцсан 1 дүгээрт.

2 дугаарт, 19 онд орсон үүнээс өмнө гарсан нэмэлт, өөрчлөлтүүдэд дандаа ийм заалтууд бас шинээр орсон өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуульд орж явсан. Үндсэн хууль зөрчсөн, Үндсэн хуультай зөрчилдсөн тухай асуудлууд гарч байгаагүй.

3-д бол, ер нь үүнийг хэдийгээр яг хуульд тодорхой заагаагүй ч гэсэн би бол Байнгын хорооны даргын хувьд $\frac{3}{4}$ -ийн саналаар явуулаад бас тодорхой хэмжээгээр нэг баталгааг нь хангах нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

С.Амарсайхан: Тийм, тэр нь дээр байх. Тийм. $\frac{3}{4}$ -аараа явах нь.

Н.Энхболд: Санал хураалт. Тийм. Санал хураалт.

14 гишүүн санал хураалтад оролцож, 11 дэмжиж, 78.6 хувиар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой асуулттай гишүүн байна уу? 3 дугаар зүйлтэй холбоотой.

2 дугаар зүйлийгээ ярьж байгаад дээр нь нэмэлт оруулах юмнуудаа өөрчлөн найруулах юмаа ярьсан.

Одоо нөгөө барьсан хуулийн 3 дахиар, 3 дахитай холбоотой юм байгаа юм. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би зүгээр дараагийн хэлэлцүүлэг дээр сая нэг хураачихсан юун дээр нэг эргээж харцгаая. Би Тамгын газрынхныг ч гэсэн үүнийг нэг хараасай гэж бодож байгаа юм. Энэ юу вэ гэхээр ингэж байгаа юм.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Энэ хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дугаар, 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах гэдэг дээр. 2 дугаар зүйл. 23 оны ... дугаар сарын ... дугаар өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн 1 дүгээр зүйлд заасан Их Хурлын нийт гишүүдийн тоо Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдсан Их Хуралд хамаарахгүй гэж байгаа. Тэгэхээр бид нар болохоор өөрчлөлтөөр тоо тогтолцоог хөндөж байгаа учраас тоо гэдгийн ард тогтолцоо гэдэг үгийг бас гишүүний тоо, түүнийг сонгосон тогтолцоо 20 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хуралд хамаарахгүй гээд яахгүй бол ийм өрөөсгөл ийм юу орж ирэх гээд байна уу л гэсэн санааг дараагийн хэлэлцүүлэг дээр хэдүүлээ анхаарвал явсан юм бэ л гэж хэлэх гэж байгаа юм.

Н.Энхболд: Ерөөсөө өргөн барьсан хуулийнхаа томъёолсон хүрээнд л бид нар асуудлууд ярьж байгаа. Үүгээр бол яах вэ нэмэгдсэн зүйлийг бол хэдийгээр бид нар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр тогтолцоог хийж болох энэ зам бол нээгдчихсэн байгаа шүү дээ, тийм ээ, одоо бол тийм. Тэгж бодоод яриагүй. Яах вэ дахиад ярья. Дараагийн хугацаанд шаардлагатай гэж үзвэл үндэслэлүүдийг нь харж байгаад дахин давхардуулж орох хэрэг байна уу, үгүй юү гэдгийг нь ярьж байгаад, байна гэж үзвэл гурав дахь хэлэлцүүлэг дээр ороод байхгүй гэвэл үүгээрээ ингээд явчихъя. Бас яг ярьсан юм. Ер нь хөндөгдсөн асуудал маань юу билээ, тэр хөндөгдсөн асуудлаас болоод өнөөдрийн Их Хурлын үйл ажиллагаанд ямар нэгэн хүндрэл учрах уу, үгүй юү гэдгийг ярьж байгаад, зөвхөн хөндөгдсөн асуудлынхаа хүрээнд гэсэн юм.

Нэмэгдсэн зүйлээ ярина гэвэл дараагийн хэлэлцүүлэг дээр ярьчихъя.

Ийм ярианууд гарсан юм. Ер нь ийм бас болгоомжлолууд байгаа. Үүний

түрүүнд бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байх үед зарим асуудлуудыг тодорхой заагаагүйгээс болоод тухайн үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдчихсан байхад Засгийн газар яагаад хуучнаараа байгаад байгаа юм бэ гэдэг асуудал гараад бас асуудал үүсэж байсан. Тэгэхээр тийм юмнуудаас аль болохоор бас сургамж аваад сэргийлэх үүднээс хөндөгдсөн асуудлаа ингээд тавьчихсан байгаа юм. Тэгээд Нямбаатар гишүүний ярьсан асуудлыг хэдүүлээ дахиад гурав дахь хэлэлцүүлгийнхээ өмнө ярья. Шаардлагатай бол энэ талаараа эргээд томъёоллуудаа харъя гэж хэлсэн байна.

Тийм, энэ төсөл маань ингэж байгаа. Энэ хуулийг 23 оны тэдэн сарын тэдний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж байгаа юм. Тэгээд энэ дундуур нь юм нь ороод дараалал нь хойшлогдоод заалт нь яг хэвээрээ, тоо нь өөрчлөгдөөд 5 болоод л явж байгаа юм. Тийм. Санал хураалт. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон 14 гишүүнээс 11 нь дэмжиж, 78.6 хувиар санал дэмжигдлээ.

Энэ Доржханд гишүүн энэ тэр бол бас ирчхээд яаралтай ажил гарлаа гээд түрүүн ажлын хэсэг дээр бүх юмтайгаа танилцаад, намайг дэмжсэн гэж үзээрэй гээд явсан юм шүү. Тэгэхдээ тэрийг зүгээр протоколд тусгачихъя. Тийм.

Хуулиа зүйл бүрээр нь хэлэлцээд дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Одоо би хэлчихнэ. Тийм.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Доржханд гишүүн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

танилцуулна. Түрүүчийнхийг би танилцуулна. Одоо энд Доржханд танилцуулна.

Энэ дээр нэг зүйлийг тодруулаад хэлчихье, гишүүд ээ.

Ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

Бид нар дараагийнхаа асуудалд оръё.

Би зүгээр энэ гурав дахь хэлэлцүүлэг эхлэхээс өмнө ингэе. Түрүүн бид нар анхны хуралдаанаараа эхний асуудлаа хэлэлцээд, тэгээд томъёоллын зарим зүйлүүдийг эргээж хараад, чуулганд оруулъя гээд зарчмын хувьд хуулийнхаа төслийг баталсан.

Тэгээд одоогийн байдлаар ийм хувилбар бэлдчихээд байж байна. Би тэрийгээ зүгээр, энэ бол танилцуулж байгаа юм. Санал байхгүй шүү.

Их Хурал нэг танхимтай байна, 126 гишүүнтэй байна. Сонгуулийг олныг төлөөлөх болон хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 76 гишүүнийг олныг төлөөлөх, 50 гишүүнийг хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн аргын үндсэн дээр сонгоно гэж томъёолсон байгаа.

Энэ дээр содон сонсогдож байгаа үг нь энэ олныг төлөөлөх гэж үг байж магадгүй. Мажоритар, пропорциональ гэдэг үгнүүдийг Үндсэн хуульдаа 1 дүгээрт оруулахгүй байя. 2 дугаарт, үүнийг төлөөлөх хэрэглэж байсан үгнүүдээ хэрэглэе гээд хэлэлцүүлэг өрнөх явцад олонхын гэдэг үгийг хэрэглээд явахаар 50 дээр нэмэх нь 1 гэж ойлгогдоод, тухайлбал одоогийн сонгууль явуулж байгаа аргатай зөрөлдөж буруу, зөрүү ойлголт үүсэх ийм юм байна гэдгийг үндэслээд тал талаас нь ярьж байгаад Хэлний үндэсний зөвлөлтэй хүртэл би Занданшатар даргыг зөвлөлдсөн гэж ингээж ойлгож байгаа.

Ингээд урьд нь манайд мажоритар гээд хэлээд тогтчихсон. Тэрийгээ өнөөдөр сонгуульд ашиглаж байгаа. Тийм ээ, жишээ нь, олон мандаттай тойргоос, ер нь аль ч мандаттай тойргоос тойргоос сонгогдож байгаа хүн 50 дээр нь нэмэх 1 гэдгийг заавал авна гэхгүйгээр хамгийн олон хүн сонгогдсон, олон санал авсан хүн нь сонгогдоод явж байгаа нэг ийм хувилбар байж байгаа. Тэр мажоритар гэдэг үг дотор. Түүнээс гадна ер нь бусад орнуудын ер нь олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа парламентын нэр томъёоллуудын зүйлээс ингээд хараад үзэхэд маш олон төрлийн ойлголтууд байдаг юм байна. Манайх шиг хэрэглэж байгаа хамгийн олон санал авсан нь байдаг, олонх байдаг, олуулаа байдаг, үнэмлэхүй олон байдаг гээд маш олныг бүгдийг нь мажоритар гэдэгт ерөнхийдөө хамруулаад явдаг юм байна. Тэгэхээр ярьж байгаад бид нар ер нь олныг нь сонгож байгаа. Олон санал авсныг нь сонгож байгаа энэ тогтолцоогоо, энэ аргаа олныг төлөөлөх гэдэг үгээр томъёолъё. Тэгээд хэрэв энэ ингээд батлагдвал энэ яваандаа Үндсэн хуульд тусгаад тэгээд хууль, эрх зүйн болоод Монгол хэлний шинжлэх ухааны энэ үгийн хэрэглээнд ороод явах ийм жишиг тогтох юм, жишигийг нь тогтоож байгаа юм гэсэн агуулгаар ийм үг бичсэн. Үүнийгээ дагаж мөрдөх шилжихдээ хэрэглэх журмын тухай хуульдаа ингээж бичээд ард нь бас одоогоор мажоритар, пропорциональ гээд биччихсэн. Түрүүн миний уншиж байсан, танилцуулсныг та бүхэн анзаарсан байх гэж бодож байна.

Тэгээд маргаашийн чуулганы нэгдсэн хуралдаанд бид нар эхний ярьсан асуудлаараа, саяын миний уншсан томъёоллоор оруулна. Байнгын хорооны гишүүд маань бас ойлголттой байх нь зөв байх гэж бодож байна.

21.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Одоо бид нар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Их хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлнэ.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14.5-д заасны дагуу төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон тогтоолын төслийг боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах ийм заалттай.

Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Их Хурлын тогтоолыг чуулганаар баталсны дараа төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж, энэ тухай нийтэд зарлаж, мэдээлэх ийм журамтай.

Би тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2023 оны 05 сарын 22-ны өдрөөс 2023 оны 05 сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар тогтоосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн бэлтгэл хангах ажлыг Монгол Улсын Их Хурлын 23 оны 37

дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг болон Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд тус тус даалгасугай.

3. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг иргэдэд тайлбарлан таниулж, тэдний санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын нийт гишүүдэд даалгасугай.

4. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Саналтай гишүүн байна уу? Асуулттай гишүүн байна уу? Асуулт алга байна. Санал алга байна.

Тэгвэл “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 64.3 хувиар санал дэмжигдэж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Адяасүрэн гишүүнээр танилцуулчихъя.

Маргааш ирэх байлгүй дээ, тийм.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

21.07 цаг

Дараагийн асуудалдаа орно.

Дараагийн асуудал Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

*хуралдааныг хаасныг, мэдэгдсэнийг
зарлах тухай асуудал байгаа юм.*

Хуралдаан хаасныг мэдэгдлээ.

Гишүүддээ баярлалаа.

Хуралдаан дууслаа.

Баярлалаа гишүүддээ.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Ц.АЛТАН-ОД

П.МЯДАГМАА

Д.ОТГОНДЭЛГЭР

Э.СУВД-ЭРДЭНЭ

Д.УЯНГА

П.ОЮУНГЭРЭЛ